



ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ

Зам, тээврийн сайдын
2025 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн
01/116.2 тоот албан бичгийн хавсралт

ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМНЫ 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2025 оны 02 дугаар сарын 25-ны өдөр



АГУУЛГА

Нэг. Зам, тээврийн яамны 2024 оны үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ ажлын товч тайлан

Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийн журмын дагуу холбогдох байгууллагуудад хүргүүлсэн тайлангуудын жагсаалт:

1. Алсын хараа 2050 МУ-ын урт хугацааны бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг Эдийн засаг хөгжлийн яаманд 2024 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн 03/2505 тоот албан бичгээр тайлагнасан.
2. Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг 2024 оны жилийн эцсийн байдлаар ЗГХХГ-т цахимаар тайлагнасан.
3. Үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх 2024 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг жилийн эцсийн байдлаар Эдийн засгийн хөгжлийн яаманд 2025 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн 01/66 тоот албан бичгээр, www.new.unelgee.gov.mn сайтад цахимаар тайлагнасан.
4. Монгол улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг жилийн эцсийн байдлаар Эдийн засгийн хөгжлийн яаманд 2025 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн 01/66 тоот албан бичгээр, www.new.unelgee.gov.mn сайтад цахимаар тайлагнасан.
5. Шинэ сэргэлтийн бодлогын 2024 оны хэрэгжилт, хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг Эдийн засгийн хөгжлийн яаманд цахимаар тайлагнасан.
6. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг 2024 оны жилийн эцсийн байдлаар Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газарт 2024 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 01/2505 тоот албан бичгээр, www.new.unelgee.gov.mn сайтад цахимаар тайлагнасан.
7. Гадаадын зээл, буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа төслүүдийн хэрэгжилт, хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг 2025 оны 02 дугаар сарын 28-ний өдөр Сангийн яаманд хүргүүлсэн.
8. Шилэн дансны хөтлөлтийн хэрэгжилтийг 2024 оны жилийн эцсийн байдлаар үнэлж, 2025 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 05/367 тоот албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн.
9. ЗТЯ-ны 2024 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөө, төлөвлөгөөний хэрэгжилтийг Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газрын www.new.unelgee.gov.mn сайтад цахимаар тайлагнасан.
10. Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр"-ийн хэрэгжилтийг Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газрын www.new.unelgee.gov.mn сайтад цахимаар тайлагнасан.
11. Ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтийг 2024 оны жилийн эцсийн байдлаар ЗГХХГ-т www.new.unelgee.gov.mn цахимаар тайлагнасан.
12. Зам, тээврийн сайд, аймгуудын Засаг дарга нарын 2024 оны хамтын ажиллагааны гэрээ, Зам, тээврийн сайд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч нарын зам, тээврийн салбарт 2021-2024 онд хамтран ажиллахаар байгуулсан "Санамж бичиг"-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-ний хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан, биелэлтийг Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газарт хүргүүлсэн.



**ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМНЫ 2024 ОНЫ
ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ
АЖЛЫН ТОВЧ ТАЙЛАН**

2025.02.25

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын зорилго:

Зам, тээврийн яам /цаашид яам гэх/-ны 2024 оны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж, үнэлэлт, дүгнэлт өгөх, цаашид анхаарч ажиллах асуудлын талаар санал, зөвлөмж боловсруулах замаар яамны удирдлага, албан тушаалтныг холбогдох мэдээллээр хангах зорилгоор энэхүү хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг гүйцэтгэлээ.

Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг дүгнэхдээ Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ, хийх нийтлэг журам", Зам, тээврийн хөгжлийн сайдын 2021 оны А/87 дугаар тушаалаар баталсан "Зам, тээврийн хөгжлийн яам болон харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам"-ыг үндэслэл болгов.

Хоёр. Танилцуулга:

Тайлант хугацаанд яамны 2024 оны үйл ажиллагааг Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө, 2024 оны яамны гүйцэтгэлийн төлөвлөгөө, Зам, тээврийн салбарын хөгжлийн үзүүлэлтийн үнэлгээ, Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр, Байгууллагын ил тод байдлын үнэлгээ, Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ зэрэг 8 үзүүлэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, санал, зөвлөмж гаргав.

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ, хийх журам"-д заасан тайлангуудыг яамны газар, хэлтэс, харьяа агентлаг байгууллагуудаас нэгтгэн авч хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлангийн хамт журамд заасан хугацаанд тухай бүр Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газар, Сангийн яам, Эдийн засаг, хөгжлийн яаманд тайлагнаж ажилласан. Мөн Зам, тээврийн хөгжлийн сайдын 2021 оны А/87 дугаар тушаалаар баталсан "Зам, тээврийн хөгжлийн яам болон харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам"-ын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнг яамны нэгж, харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд улирал хагас жил, жилийн эцсийн байдлаар дүгнэх үзүүлэлт болгон ашигласан. Эдгээрийг тус тусад нь авч үзвэл:

2.1. Хууль, тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт:

2024 оны жилийн эцсийн байдлаар Монгол Улсын 6 хуулийн 24 заалт, Улсын Их Хурлын 21 тогтоолын 41 заалт, Улсын Их Хурлын Байнгын хорооны 6 тогтоолын 12 заалт, Ерөнхийлөгчийн 1 зарлигийн 2 заалт, Засгийн газрын 81 тогтоолын 114 заалт, Засгийн газрын хуралдааны 75 тэмдэглэлийн 162 заалт, Засгийн газрын 3 албан даалгаврын 26 заалт, Ерөнхий сайдын 4 захирамжийн 5 заалт, Үндэсний аюулгүй



ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ

байдлын зөвлөлийн 1 зөвлөмжийн 1 заалт буюу нийт 198 шийдвэрийн 387 заалтыг хяналтад авч хэрэгжүүлэн ажилласан.

Мөн салбарын хуулиар тусгайлан журам боловсруулж батлахаар эрх олгосон дүрэм, журмын судалгааг гаргаж, яамны холбогдох газар, хэлтэст хүргүүлэн хуульд заасан эрх зүйн акт /дүрэм, журам, заавар, бусад/-ыг хугацаанд нь баталж мөрдүүлэх арга хэмжээ авч ажилласан. Иргэний нисэхийн тухай хууль, Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулга 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхлэхтэй холбогдуулан эдгээр хуулиудаар эрх зүйн акт /дүрэм, журам, заавар/ батлахаар эрх олгогдсон заалтыг хяналтад авч эдгээр дүрэм, журмыг боловсруулж батлуулах ажлын хэсгүүд байгуулан ажиллаж байна. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн нэгдсэн дүн 2024 оны жилийн эцсийн байдлаар эрх зүйн ангиллаар үнэлгээг үзүүлбэл:

/Хүснэгт 1/

Хууль тогтоомж, тогтоол шийдвэр	Бүгд	Үүнээс								
		МУ-ын хууль	Улсын Их Хурлын тогтоол	УИХ-ын Байнгын хорооны тогтоол	Ерөнхийлөгчийн зарлиг	Засгийн газрын тогтоол	Засгийн газрын хуралдааны тэмдэглэл	Засгийн газрын албан даалгавар	Ерөнхий сайдын захирамж	ҮАБЗ-ийн хуралдааны тэмдэглэл
Хяналтад авсан нийт шийдвэрийн тоо	198	6	21	6	1	80	75	3	4	1
Хяналтад авсан нийт зүйл, заалтын тоо	387	24	41	12	2	113	162	26	5	1
Үүнээс	Бүрэн хэрэгжсэн 100%	242	8	20	8	-	75	123	5	3
	Хэрэгжих шатанд 70%	126	12	16	4	2	36	36	16	2
	Хэрэгжилт хангалтгүй 30%	9	2	1	-	-	1	5	-	-
	Хэрэгжээгүй	-	-	-	-	-	-	-	-	-
	Хугацаа болоогүй	9	-	3	-	-	2	2	-	-
	Хүчингүй болсон	-	-	-	-	-	-	-	-	-
Биелэлтийн дүн /хувь/	88.3	77.2	85.1	90.0	70.0	90.2	92.8	68.0	88.0	70.0

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд бүрэн хэрэгжсэн 242, хэрэгжих шатанд буюу 70 хувийн хэрэгжилттэй 126, хэрэгжилт хангалтгүй 30 хувийн хэрэгжилттэй 9 арга хэмжээ, хугацаа болоогүй 9 арга хэмжээний дундаж үнэлгээ 88.3 хувиар үнэлэгдсэн байна.

Засгийн газрын 2020 оны 206 дүгээр тогтоолоор баталсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-д заасны дагуу 2024 оны жилийн эцсийн байдлаар Хууль



ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ

тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газарт 2024 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 01/2505 тоот алба н бичгээр, www.new.unelgee.gov.mn сайтад цахимаар тайлагнасан.

2.2. МУ-ын ЗГ-ын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт:

Засгийн газрын 2021 оны 203 дугаар тогтоолоор баталсан Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд Зам, тээврийн сайдын хариуцан хэрэгжүүлэх 96 арга хэмжээний биелэлтийг 2024 оны хагас жилийн байдлаар үнэллээ. Хөтөлбөрийн хэрэгжүүлэх төлөвлөгөөний хэрэгжилт дунджаар **75.0** хувьтай байна.

Төлөвлөгөөнд туссан арга хэмжээний үнэлгээг авч үзвэл дараах байдалтай байна. Үүнд:

№	Нийт	ХШҮ хувь	Үнэлгээ /хувиар/												Хугацаа болоогүй
			100	90	70	50	30	0	99	95.6	93.5	91	78	74	
96		75.0	25	9	15	6	12	1	1	1	1	1	1	1	22

Хөтөлбөрийн хэрэгжилтэд 0-30 хүртэл хувийн биелэлттэй 13 арга хэмжээг эрчимжүүлэх шаардлагатай гэж үнэллээ. Үүнд:

- Улаанбаатар төмөр замын гол замд 200 км их засвар хийх;
- Дорнод аймгийн Чойбалсан хотыг Хавиргын боомттой холбох 124.5 км хатуу хучилттай авто замыг барих;
- Баянхонгор аймгийн төвөөс Шаргалжуут чиглэлийн 54.17 км хатуу хучилттай авто замын төслийг эхлүүлэх;
- Хужирт-Арвайхээр чиглэлийн 56 км хатуу хучилттай авто замыг барих;
- Сүхбаатар аймгийн Баруун-Урт-Арбулаг чиглэлийн 60 км хатуу хучилттай авто замыг барих;
- Ховд-Улаангом чиглэлийн 163.3 км хатуу хучилттай авто замыг барих /Ховд, Увс аймаг/;
- Завхан аймгийн Улиастай сумын Богд Чигэстэйн голын 290.03 у/м төмөр бетон гүүрийг барих;
- Говь-Алтай аймгийн Жаргалант сумын Завхан голын төмөр бетон гүүрийг барих;
- Өвөрхангай аймгийн Арвайхээр сумын Онгийн голын 166 у/м төмөр бетон гүүрийг барих;
- Өвөрхангай аймгийн Хархорин сумын Орхоны голын 290 у/м төмөр бетон гүүрийг барих;
- Архангай аймгийн Тариат сумын Гичгэнийн голын 90 у/м төмөр бетон гүүрийг барих;
- Ховдын Булган, Хэнтий Дадал сумын нисэх буудлын аэродромд их засвар хийх;
- Олон улс, улсын чанартай авто замын төлбөр авах цэгийг цахимжуулах, Мөрөн, Чойр, Даланзадгад, Түмэнцогт, Хяргас нуур орчимд төлбөр авах цэг байгуулах.



Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-д заасны дагуу Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилтын хэрэгжилтийг 2024 оны жилийн эцсийн байдлаар Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газарт цахимаар тайлагнасан.

2.3. Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний хэрэгжилт:

Монгол Улсын Улсын Их Хурлын 2023 оны 39 дүгээр тогтоолоор батлагдсан Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд зам, тээврийн салбарт хэрэгжүүлэхээр туссан 4 зорилтыг хэрэгжүүлэх нийт 46 арга хэмжээ туссан байна. Үүнд:

- Авто замын салбарт 2 зорилтыг хэрэгжүүлэх 32 арга хэмжээ
- Төмөр зам, далайн тээврийн салбарт 2 зорилтыг хэрэгжүүлэх 7 арга хэмжээ
- Иргэний нисэхийн салбарт 1 зорилтыг хэрэгжүүлэх 5 арга хэмжээ
- Автотээврийн салбарт 1 зорилтыг хэрэгжүүлэх 2 арга хэмжээ

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ, хийх нийтлэг журам"-ын дагуу үнэлэхэд Зам, тээврийн салбарт хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 4 зорилтын хэрэгжилт **92.5%**, зорилтуудыг хэрэгжүүлэх 46 арга хэмжээний хэрэгжилт **53.8%**, Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүнгийн шалгуур үзүүлэлт **64.3%**, хөтөлбөрийн үр дүнгийн шалгуур үзүүлэлт **84.9**-тай үнэлэгдлээ.

Хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээнүүдийн биелэлтийг салбараар үзүүлбэл:

/Хүснэгт 3/			
Салбар	Зорилтын тоо	Арга хэмжээний тоо	Хэрэгжилтийн хувь
Авто зам	2	32	55.4
Төмөр зам, далайн тээвэр	2	7	40.0
Иргэний нисэх	1	5	44.0
Автотээвэр	1	2	100.0
Нийт	4	46	53.8

Монгол улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг жилийн эцсийн байдлаар Эдийн засгийн хөгжлийн яаманд 2025 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн 01/66 тоот албан бичгээр, Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газрын www.new.unelgee.gov.mn сайтад цахимаар тайлагнасан.

2.4. Зам, тээврийн салбарын Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн үнэлгээ:

Зам, тээврийн салбарын Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийг дүгнэхдээ суурь түвшинг 2023 оны гүйцэтгэлээр авч, 2024 оны гүйцэтгэлтэй харьцуулан өсөлт, бууралтын хувиар тооцов. Салбарын 2024 оны Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн хэрэгжилтийг жилийн эцсийн байдлаар үнэлэхэд 16 зорилтын 35 заалтаас 26 заалт өсөлттэй бол бууралттай 3 заалт, үнэлгээнд тооцох боломжгүй 6 заалт байна.



ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ

Өсөлттэй үзүүлэлтүүдийг 100 хувь гэж дүгнэвэл Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн хэрэгжилт дунджаар 89.6 хувийн биелэлттэй байна. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 3.1 функтээр өссөн байна.

/Хүснэгт 4/

№	Үзүүлэлт	Тээврийн төрөл	Суурь үзүүлэлт /2023 он/	2024 он		ХШҮ /хувиар/
				Гүйцэтгэл	Өсөлт/бууралт хувиар	
1	Тээвэрлэсэн ачаа (мян.тонн)	Автотээвэр	71,254.9	85,165.5	19.5%	100
		Төмөр замын тээвэр	36,114.2	45,899.1	27.1%	100
		Агаарын тээвэр	8.6	10.4	21.2%	100
2	Дамжин өнгөрөх (транзит) ачаа (мян.тонн)	Төмөр замын тээвэр	5,094.4	5299.2	22.1	100
3	Ачаа эргэлт (сая тонн/ км)	Автотээвэр	10,619.1	12,746.1	20.0%	100
		Төмөр замын тээвэр	18,869.3	21,217.6	12.4%	100
		Агаарын тээвэр	24.3	29.0	19.3%	100
4	Зорчигчдын тоо (сая.хүн)	Автотээвэр	142,553.0	145,117.9	1.8%	100
		Төмөр замын тээвэр	2,141.8	1,976.5	-7.7%	0
		Усан замын тээвэр	64.7	94.2	45.7%	100
		Агаарын тээвэр	1,731.3	2,167.3	25.2%	100
5	Зорчигч эргэлт (сая хүн/ км)	Автотээвэр	1,813.2	2,204.5	21.6%	100
		Төмөр замын тээвэр	797.5	786.1	-1.4%	0
		Агаарын тээвэр	3,880.8	4,894.0	26.1%	100
6	Тээвэрлэлтийн орлого (тэрбум төгрөг)	Автотээвэр	4,676.4	5,019.0	7.32	100
		Төмөр замын тээвэр	1,125.0	1,648.1	46.48%	100
		Агаарын тээвэр	941.9	1,130.9	16.8%	100
7	Зам, тээврийн салбарт шинээр нэвтрүүлсэн техник, технологийн тоо	Зам, тээвэр	3	2	-	Үнэлэх боломжгүй
8	Нийслэл хоттой хатуу хучилттай авто замаар холбогдсон аймгийн төвийн тоо	Авто зам	21	21	-	Үнэлэх боломжгүй
9	Олон улсын чанартай авто	Авто зам	7,535.60	8095.1	7.42	100



ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ

	замын сүлжээн дэх хатуу хучилттай авто замын сүлжээний урт (өссөн дүнгээр) (км)					
10	Шинээр ашиглалтад оруулах замын урт (км)	Авто зам	381.4	567.1	46.6%	100
		Төмөр зам	286.9	-	-	Үнэлэх боломжгүй
11	Шинээр ашиглалтад орсон гүүрийн урт (м)	Авто зам	841.87	208.9	-	100
12	Тээврийн чиглэлийн тоо	Автотээвэр	215	110.0	124.5%	100
		Олон улсын нислэг	43	59.0	37.2%	100
13	Буулт, хөөрөлтийн тоо (мян.)	Агаарын тээвэр	19.96	23.95	19.98%	100
14	Олон улсын өнгөрөлтийн нислэгийн тоо (мян.)	Агаарын тээвэр	43.5	67,824	55.9%	100
15	Тээврийн хэрэгслийн парк шинэчлэлт	Автобус	279	600	115.0%	100
		Зүтгүүр	190	208.0	9.5%	100
		Ачааны вагон	6,874	11,257.0	63.76%	100
		Зорчигчийн вагон	321	321.0	-	Үнэлэх боломжгүй
		Агаарын хөлөг	60	31	-	Үнэлэх боломжгүй
16	Вокзал буудлын тоо (өссөн дүнгээр)	Автовокзал	25	25.0	-	Үнэлэх боломжгүй
		Төмөр замын буудлын тоо	70	100.0	42.9%	100
		Нисэх буудлын тоо	25	25.0	-	Үнэлэх боломжгүй

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д заасны дагуу Салбарын эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн хэрэгжилтийг 2024 оны жилийн эцсийн байдлаар Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газрын www.new.unelgee.gov.mn сайтад цахимаар тайлагнасан.

2.5. Яамны 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт:

Зам, тээврийн яамны 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 145 арга хэмжээг хэрэгжүүлэхээс бүрэн хэрэгжсэн 60 арга хэмжээ, 90 хувийн 33, 70 хувийн 15, 50 хувийн 24, 30 хувийн 13 арга хэмжээний хэрэгжилт **80.0** хувь байна.

Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд хариуцсан нэгж, хэрэгжүүлэх үндсэн чиг үүргээр /давхардсан тоогоор/ хэрэгжилтийг авч үзвэл:

/Хүснэгт 5/

№	Нэгж	Нийт	Үнэлгээ /хувиар/	Хугацаа болоогүй	Үнэлгээ /хувиар/
---	------	------	------------------	------------------	------------------



ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ

			100	90	70	50	30	0		
1	БТГ	15	6	2	2	2	3	-	-	74.0
2	АЗБЗГ	33	12	9	3	5	4	-	-	78.5
3	ИНБЗГ	18	10	3	1	3	1	-	-	84.4
4	АТБЗГ	25	12	1	5	5	2	-	-	78.0
5	ТЗДТБЗГ	40	16	4	6	9	5	-	-	74.5
6	ТЗУГ	22	8	11	3	-	-	-	-	90.9
7	ХШУДАГ	6	2	3	1	-	-	-	-	90.0
8	СХГ	9	7	2	-	-	-	-	-	97.8

Зам, тээврийн яамны 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд хэрэгжилт хангалтгүй буюу 30 хувийн хэрэгжилттэй 13 арга хэмжээ байна. Үүнд:

- Арга хэмжээ 2.6. "Чойбалсан-Хөөт-Бичигт чиглэлийн 426.7 км төмөр замын төслийн хүрээнд Бичигт-Зүүнхатавч боомтын хил холболтын төмөр замын барилгын ажлыг эхлүүлэх" /ТЗДТБЗГ 2-4 улирал/;
- Арга хэмжээ 2.7. "Арцсуурь-Шивээхүрэн-Нарийнсухайт чиглэлийн 1255 км төмөр замын төслийн хүрээнд Шивээхүрэн-Нарийнсухайт-Шинэжинст чиглэлийн төмөр замын төслийг эхлүүлэх" /ТЗДТБЗГ 3-4 улирал/;
- Арга хэмжээ 2.12. "Улаанбаатар-Хархорин чиглэлийн төмөр замын техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах" /ТЗДТБЗГ 1-4 улирал/;
- Арга хэмжээ 3.16. "Авто замын барилгын ажлын явцад замын хөдөлгөөний аюулгүй байдлын аудит хийх тогтолцоог бүрдүүлэх" /АТБЗГ 1-2 улирал/;
- Арга хэмжээ 3.18. "Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль болон Замын хөдөлгөөний дүрмийн хэрэгжилтэд хөндлөнгийн аудит хийж, эрх зүйн зохицуулалтыг сайжруулах" /АТБЗГ 1-4 улирал/;
- Арга хэмжээ 4.5. "Ховд-Улаангом чиглэлийн 163 км хатуу хучилттай авто замын барилгын ажлыг эхлүүлэх" /АЗБЗГ 2-4 улирал/;
- Арга хэмжээ 4.12. "Баяндалай-Гурвантэс чиглэлийн 80 км хатуу хучилттай авто замын барилгын ажлыг эхлүүлэх" /АЗБЗГ 1-4 улирал/;
- Арга хэмжээ 4.25. "Хилийн 5 боомтыг тусгай зориулалтын хатуу хучилттай авто замаар холбох ажлыг үргэлжлүүлэх" /АЗБЗГ 1-4 улирал/;
- Арга хэмжээ 5.9. "Чингис хаан" олон улсын нисэх буудалд транзит зочид буудал, шатахуун хангамжийн байгууламж байгуулах ажлыг эхлүүлэх" /ИНБЗГ, 1-4 улирал/;
- Арга хэмжээ 6.5. "Дорноговь аймгийн Замын-Үүд сумын "Бүс нутгийн логиستيкийн төв"-ийг түшиглэн хуурай боомт байгуулах техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах" /ТЗДТБЗГ 1-3 улирал/;
- Арга хэмжээ 9.2. "Зам, тээврийн салбарын хүний нөөцийг хөгжүүлэх төлөвлөгөөг батлуулах" /БТГ, 1-4 улирал/;
- Арга хэмжээ 9.10. "Шинжлэх ухаан, технологийн их сургуультай хамтран зам, тээврийн салбарын судалгаа, шинжилгээний төвийг байгуулах бэлтгэл ажлыг эхлүүлэх" /БТГ, 1-4 улирал/;



ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ

- Арга хэмжээ 10.3. “Зам, тээврийн салбарын бүтээн байгуулалт, үйл ажиллагаанд шинэ технологи, инновац нэвтрүүлэх туршилт, судалгаа хийх” /БТГ, АЗБЗГ, ТЗДТБЗГ 1-4 улирал/

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д заасны дагуу ЗТЯ-ны 2024 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөө, төлөвлөгөөний хэрэгжилтийг Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газрын www.new.unelgee.gov.mn сайтад цахимаар тайлагнасан.

2.6. Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хэрэгжилт:

“Зам, тээврийн яамны албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-ийг Төрийн нарийн бичгийн даргын 2023 оны Б/88 дугаар тушаалаар баталсан.

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ үнэлгээ хийх нийтлэг журам”-д заасан хүснэгтийн дагуу Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн 2024 оны биелэлтийг тайлагнахад 7 зорилтын 26 арга хэмжээний хэрэгжилт 97.1 хувьтай үнэлэгдлээ. Нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн зорилтын хэрэгжилтийг хүснэгтээр үзүүлбэл:

/Хүснэгт 6/

№	Үйл ажиллагаа	Хэрэгжилтийн хувь
1. Хүний нөөцийг хөгжүүлэх, идэвхжүүлэх		
1	Засгийн газар, төрийн байгууллага, бусад байгууллагаас албан хаагчдын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулсан дотоод сургалт	100
2	Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр байгууллагын болон зохион байгуулагч талын зардлаар хамруулсан гадаад сургалт	100
3	Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр зарцуулсан зардал, албан хаагчдын шилжилт хөдөлгөөн	100
2. Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах		
4	Цалин хөлс, шагнал, урамшууллын тогтолцоог хэрэгжүүлэх	100
5	Албан хаагчдын ажлын байрны хэвийн нөхцөлийг бүрдүүлэх	90
6	Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх	100
7	Албан хаагчдыг нийгмийн баталгааг хангах чиглэлээр зарцуулсан зардал	90

Засгийн газрын 2020 оны 206 дүгээр тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д заасны дагуу Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг 2024 оны жилийн эцсийн байдлаар Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газрын www.new.unelgee.gov.mn сайтад цахимаар тайлагнасан.

2.7. Ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн хэрэгжилт:



ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ

Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийг хэрэгжүүлэх, төрийн үйл ажиллагааг нээлттэй, ил тод, хүнд сурталгүй, авилгаас ангид байлгах, иргэдэд үйлчлэх үйлчилгээг ил тод хөнгөн шуурхай болгох, хангах талаар Зам, тээврийн яамнаас хийж буй ажлын явцад Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ, хийх нийтлэг журам”-ын 9 дүгээр хавсралтад заасан ил тод байдлын шалгуур үзүүлэлтүүдийн дагуу үнэллээ.

Зам, тээврийн яамны Нийтийн мэдээллийн ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн 5 хэсгийн 46 арга хэмжээний хэрэгжилт 2024 оны жилийн эцсийн байдлаар 92.8 хувь байна. Шалгуур үзүүлэлт тус бүрийн үнэлгээг хүснэгтээр харуулбал:

/Хүснэгт 7/

Хэсэг	Нийт арга хэмжээ	Үнэлгээ /хувиар/					Хамаарахгүй	ХШҮ
		100	70	30	0	Хугацаа болоогүй		
1	10	9	-	1	-	-	-	93.0
2	6	5	-	-	1	-	-	83.3
3	15	13	1	1	-	-	-	93.3
4	2	2	-	-	-	-	-	100.0
5	13	8	1	-	-	-	4	96.2
Нийт	46	37	2	2	1	-	4	92.8

2024 оны жилийн эцсийн байдлаар Зам, тээврийн яамны мэдээллийн ил тод, нээлттэй байдлын шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтэд 0-30 хувийн хэрэгжилттэй үнэлэгдсэн 3 арга хэмжээг дурдвал:

/Хүснэгт 8/

№	Арга хэмжээ	Хэрэгжилт	Үнэлгээ
Нэг. Чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал			
1	Хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлан	Хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний одоогоор хийгдсэн хууль байхгүй байна. Харин яамны сайтад хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хийсэн ХШҮ-ний тайланг тухай бүр нээлттэй байршуулан ажиллаж байна.	30
Хоёр. Хүний нөөцийн мэдээллийн ил тод, нээлттэй байдал			
2	Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж үнэлэх журам	Зам, тээврийн салбарын хүний нөөцийн стратеги, бодлогын боловсруулж байгаа бөгөөд салбарын байгууллагууд болон зам, тээврийн чиглэлээр суралцаж буй оюутан залуусын санал, зөвлөмжийг тусгасан урт хугацаандаа хэрэгжүүлэх бодлого, мөн харьяа байгууллага бүрийг өөрийн салбар үйл ажиллагаатай уялдуулан Хүний нөөцийн стратеги төлөвлөгөө боловсруулан батлуулахыг үүрэг болгосон.	0
Гурав. Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал			
3	Мэдээлэл хариуцагч болон захиалагч байгууллагын хүсэлтээр холбогдох этгээдийг худалдан авах ажиллагааны мэргэжил, арга зүйн зөвлөгөө,	Худалдан авах ажиллагаатай холбоотой мэдээллийг байршуулав.	30



ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ

зааварчилгаагаар хангасан тухай мэдээлэл		
--	--	--

Засгийн газрын 2020 оны 206 дүгээр тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д заасны дагуу Мэдээллийн ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтийг 2024 оны жилийн эцсийн байдлаар Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газрын www.new.unelgee.gov.mn сайтад цахимаар тайлагнасан.

2.8. Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байршуулах мэдээллийн нэгдсэн тайлангийн хэрэгжилт:

Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйл, Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох” журмыг үндэслэн шилэн дансны цахим хуудсанд байршуулсан мэдээллийн агуулга, стандартын хэрэгжилтэд Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас аудит хийж ажиллаж байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцад хамаарах болон эрхлэх асуудлын хүрээний төсвийн байгууллага, төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчит хувьцаат компаниудыг хамруулан нийт 92 нэгж, байгууллагын 2024 оны 4 дүгээр улирлын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт хийв. Үүнд:

- Улсын төсвийн байгууллага-5;
- Төсөл, арга хэмжээ-6;
- Төрийн өмчит үйлдвэрийн газар-51;
- Төрийн өмчит хувьцаат компани-24;
- Хувь нийлүүлсэн нийгэмлэг-1;
- Төрийн өмчит ХХК-3;
- Засгийн газар, орон нутгийн тусгай сан-2 байна.

Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар нь чиг үүргийн дагуу Шилэн дансны тухай хууль, Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журмын хэрэгжилтийг хангуулахаар яамны дотоод аппарат болон харьяа байгууллагуудад хяналт тавин ажиллаж байна.

Тайлант оны жилийн эцсийн байдлаар Зам, тээврийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах Шилэн дансны тухай хуульд заасны дагуу мэдээлэл байршуулах үүрэг бүхий 92 нэгж, байгууллага нийт тайлагнавал зохих 14,076 мэдээллээс 14,059 мэдээллийг цахим системд байршуулсан ба үүнээс 13,902 мэдээллийг хуульд заасан хугацаанд, 157 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт салбарын дунджаар 98.8 хувийн биелэлттэй байна.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн 2024 оны тайланг 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 05/367 тоот албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн.

ГУРАВ. ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ

3.1. Тайлант хугацаанд яамны 2024 оны үйл ажиллагааг яамны гүйцэтгэлийн төлөвлөгөө, Шинэ сэргэлтийн бодлого, “Алсын хараа 2050” урт хугацааны бодлогын



ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ

баримт бичиг, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө, Шинэ сэргэлтийн бодлого, Зам, тээврийн салбарт хэрэгжиж буй гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж буй төсөл, Төрөөс төмөр замын талаар баримтлах бодлогын баримт бичиг, Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, Сайд, Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар өгөгдсөн үүрэг даалгавар, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх асуудлын төлөвлөгөө, Төрийн нарийн бичгийн даргын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэх асуудлын төлөвлөгөө, Төрийн нарийн бичгийн даргын зөвлөлийн хуралдаанаас гарсан шийдвэр, 21 аймагтай байгуулсан гэрээ, Нийслэлийн Засаг даргатай байгуулсан "Санамж бичиг", Мэдээллийн ил тод байдал, Шилэн дансны хөтлөлт, яамны нэгж, харьяа байгууллагуудын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө зэрэг бодлогын бичиг баримт, төлөвлөгөө, удирдлагаас өгсөн үүрэг даалгаврууд зэрэг 18 үзүүлэлтээр байнгын хяналт тавин улирал, хагас жил, бүтэн жилийн байдлаар давхардсан тоогоор 126 удаа хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, санал, зөвлөмж гарган ажилласан.

3.2. Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ, хийх журам"-д заасан тайлангуудыг яамны газар, хэлтэс, харьяа агентлаг байгууллагуудаас нэгтгэн авч хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлангийн хамт журамд заасан хугацаанд тухай бүр Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газар, Сангийн яам, Эдийн засаг, хөгжлийн яаманд тайлагнаж, хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнг яамны нэгж, харьяа байгууллагуудын үйл ажиллагааг улирал хагас жил, жилийн эцсийн байдлаар дүгнэх үзүүлэлт болгон ашигласан.

3.3. Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ, хийх журам"-д заасны дагуу Зам, тээврийн яамны 2024 оны үйл ажиллагааг дүгнэвэл:

Үзүүлэлт		Хувь	Жин	Оноо
1	2	3	4	5
Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээ	1. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт	88.3	0.6	2.3
	2. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт	75.0		
	3. Монгол Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний биелэлт	53.8		
	4. Салбарын хөгжлийн үзүүлэлтийн үнэлгээ	89.6		
Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээ	1. Байгууллагын тухайн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт	80.1	0.2	0.88
	2. Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлт	97.1		
Байгууллагын нээлттэй байдлын үнэлгээ	1. Байгууллагын ил тод байдлын үнэлгээ	92.8	0.2	0.95
	2. Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ	98.8		
	3. Байгууллагын шударга байдлын түвшний үнэлгээ	-		
	4. Хэрэглэгчийн үнэлгээ	-		
ЕРӨНХИЙ ҮНЭЛГЭЭ		82.8	1.0	4.1



ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ

Шударга байдлын үнэлгээг Авлигатай тэмцэх газар, Хэрэглэгчийн үнэлгээг Засгийн газрын хэрэг эрхлэх газраас нэгдсэн байдлаар үнэлдэг болно.

Ерөнхий үнэлгээ хийсэн аргачлал:

$$\Sigma = 0.05 * [(88.3 + 75.0 + 53.8 + 89.6) \div 4 * 0.6 + (80.1 + 97.1) \div 2 * 0.2 + (92.8 + 98.8) \div 2 * 0.2] = 0.05(46.00 + 17.72 + 19.16) = 4.14$$

ДӨРӨВ. САНАЛ ЗӨВЛӨМЖ

4.1. Монгол Улсын урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичигт туссан ч хөрөнгө, санхүүжилт шийдэгдээгүй байгаа арга хэмжээнүүдийн талаар Сангийн яаманд төсөвт тусгуулах санал хүргүүлэхээс гадна гадаадын зээл, тусламж, төрийн хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх боломжийг судлан бусад арга замаар хөрөнгө оруулалт шийдэх, эрчимжүүлэх чиглэлээр идэвх санаачилгатай ажиллах, хөрөнгийн асуудлыг шийдвэрлэх санал боловсруулж, шийдвэрлүүлэх арга хэмжээ авах, төрийн худалдан авах үйл ажиллагаатай холбоотойгоор төсөл, арга хэмжээний хэрэгжилт удааширч байгааг анхаарч, ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах ажлуудыг төлөвлөсөн хугацаанд багтаан хэрэгжүүлж ажиллахыг Бодлого, төлөвлөлтийн газар, болон бодлого зохицуулалтын газруудад;

4.2. Яамны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан боловч бүрэн хэрэгжээгүй арга хэмжээ болон бодлогын баримт бичигт туссан арга хэмжээнүүд, Хууль тогтоомж, тогтоол шийдвэрээр зам, тээврийн салбарт өгөгдсөн үүрэг даалгаврууд, бусад төлөвлөгөөнд туссан ч хэрэгжилт хангалтгүй байгаа бусад арга хэмжээний хэрэгжилтэд 2025 оны эхнээс хяналт тавьж, тэдгээр арга хэмжээнүүдийг эрчимжүүлэн ажиллахыг яамны нийт албан хаагчдад;

4.3. Төмөр замын тээврийн тухай хууль, Иргэний нисэхийн тухай хуулиуд хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан эдгээр хуульд заасан эрх зүйн баримт бичгүүдийг шинэчлэн боловсруулж, батлуулах, Автотээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулга, Авто замын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах ажлыг 2025 оны эхний хагас жилд багтаан хэрэгжүүлэхийг Төрийн захиргааны удирдлагын газар болон бодлого зохицуулалтын газруудад;

4.4. Төрийн нарийн бичгийн даргын 2023 оны Б/88 дугаар тушаалаар баталсан "Зам, тээврийн яамны албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг жил бүр батлуулах, хагас, бүтэн жилийн байдлаар хэрэгжилтийг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт тайлагнаж, хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлангаар өгсөн санал, зөвлөмжийг хэрэгжүүлэх, мөн төрийн үйл ажиллагааг нээлттэй байлгах, иргэдэд үйлчлэх үйлчилгээг ил тод хөнгөн шуурхай болгоход онцгойлон анхаарч ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газар болон Бодлого төлөвлөлтийн газарт;

4.5. Холбогдох тайлан, мэдээллийг тодорхой тоо баримт, огноотой, товч тодорхой бичиж, хийсэн ажлаа бүрэн тайлагнаж, журамд заасан хугацаанд ирүүлж байхад яамны нийт ажилтан, албан хаагч анхаарч ажиллахыг тус тус зөвлөж байна.

ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ.



Хавсралт

1. ЗТЯ-ны 2024 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд 2024 оны жилийн эцсийн байдлаар хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан /21 хуудастай/;
2. “Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр”-ийн хэрэгжилтэд 2024 оны жилийн эцсийн байдлаар хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан /4 хуудастай/;
3. Ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтэд 2024 оны жилийн эцсийн байдлаар хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан /4 хуудастай/.



Хавсралт 1

ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМНЫ 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТОВЧ ТАЙЛАН

1. Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын зорилго:

Зам, тээврийн яамны 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ хийж, үнэлэлт, дүгнэлт өгөх, цаашид анхаарч ажиллах асуудлын талаар санал, зөвлөмж боловсруулах замаар яамны удирдлага, албан тушаалтныг холбогдох мэдээллээр хангах зорилгоор энэхүү хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг хийлээ.

Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг дүгнэхдээ Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ, хийх нийтлэг журам”, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2021 оны А/87 дугаар тушаалаар баталсан “Зам, тээврийн хөгжлийн яам, харьяа байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ, хийх журам”-ыг тус тус үндэслэл болгов.

2. Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт:

Зам, тээврийн яамны 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 10 дугаар сарын 18-ны өдөр шинэчлэн батлагдсан. Төлөвлөгөөнд 145 арга хэмжээг хэрэгжүүлэхээс бүрэн хэрэгжсэн 60 арга хэмжээ, 90 хувийн 33, 70 хувийн 15, 50 хувийн 24, 30 хувийн 13 арга хэмжээний хэрэгжилт **80.1** хувь байна.

Хүснэгт 1\

Төлөвлөсөн арга хэмжээний тоо	Үнэлгээ /хувиар/							ХШҮ \дундаж\
	100	90	70	50	30	0	Хугацаа болоогүй	
145	60	33	15	24	13	-	-	80.1

Төлөвлөгөөнд 30-50 хувийн хэрэгжилттэй байгаа 37 арга хэмжээний биелэлтийг хүснэгт 2 үзүүлээ.

Хүснэгт 2\

Д/д	Арга хэмжээ, зорилт	Зорилтот түвшин, /хэрэгжих дуусах хугацаа/	Хариуцах нэгж	Биелэлт
30 хувийн хэрэгжилттэй арга хэмжээ				
2.6	Чойбалсан-Хөөт-Бичигт чиглэлийн 426.7 км төмөр замын төслийн хүрээнд Бичигт-Зүүнхатавч боомтын хил	Жилийн эцсийн байдлаар: Хил холболтын төмөр замын барилгын ажлын гүйцэтгэлийг 40 хувьд хүргэнэ.	ТЗДТБЗГ	Зүүн босоо төмөр замын Концессын гэрээний хэлэлцээний явцад төслийг хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын хэмжээг бууруулах саналыг дэмжээгүй тул гэрээний төсөл байгуулаагүй байна. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль 2024 оны 01 сарын 01-нээс хүчин төгөлдөр хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор өмнө гарсан тогтоол шийдвэрүүдийг хэрхэх талаар чиглэл ирээгүй байна.

ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ

	холболтын төмөр замын барилгын ажлыг эхлүүлэх			Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд түншлэлээр хэрэгжүүлэх төслийн ТЭЗҮ-г сүүлийн 3 жилийн дотор хийсэн байх тухай заасан байдаг. "Чойбалсан - Бичигт" чиглэлийн төмөр замын төслийн Техник-Эдийн засгийн үндэслэл боловсруулах ажлын хүрээнд "Монголын төмөр зам" ТӨХК болон "Ниппон коей" компаниудын 2013 оны 02 дугаар сард хийсэн "Монгол Улсын шинэ төмөр замын төслийн техникийн зөвлөгөө өгөх үйлчилгээ-зураг төслийн тайлан"-г орчуулж ТЭЗҮ-г боловсруулахаар ажиллаж байна. Мөн Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2023 оны 02 дугаар сарын 07-ны өдөр баталсан Бичигт-Зүүнхатавч боомтын хил дамнасан төмөр замын суурь бүтэц барих техник-эдийн засгийн үндэслэл боловсруулах ажлын даалгавар мөн 2023 оны 03 дугаар сарын 17-ны өдөр баталсан инженерийн нарийвчилсан зураг төсөл боловсруулах ажлын даалгаврын дагуу "Монголын төмөр зам" ТӨХК боловсруулж Зам, тээврийн яамны Шинжлэх ухаан технологийн дэд зөвлөлөөр 2024 оны 05 дугаар сард хэлэлцсэн. "Монголын төмөр зам" ТӨХК ТЭЗҮ-г сайжруулан боловсруулж байна. Мөн ийстерн рэйлвэй девелопмент ХХК-иас тус чиглэлийн төмөр замын төсөлд оролцох хүсэлтээ ТЭЗҮС, зураг төслийн хамт ирүүлсэн. ТЭЗҮС-ыг ЗТЯ-ны ТЗДТБЗГ-ын ШУТ-ийн дэд зөвлөлөөр хэлэлцүүлэхээр ажиллаж байна. Хэрэв ШУТ-ийн дэд зөвлөлөөр хэлэлцэгдээд дэмжигдвэл ТХХТ-ийн тухай хуулийн хүрээнд урьдчилсан үнэлгээг хийж ЭЗХЯ руу явуулна.
2.7	Арцсуурь-Шивээхүрэн-Нарийнсухайт чиглэлийн 1255 км төмөр замын төслийн хүрээнд Шивээхүрэн-Нарийнсухайт-Шинэжинст чиглэлийн төмөр замын төслийг эхлүүлэх	Жилийн эцсийн байдлаар: Шивээхүрэн-Нарийнсухайт-Шинэжинст чиглэлийн 300 км төмөр замын барилгын ажлын гүйцэтгэлийг 30 хувьд хүргэнэ.	ТЗДТБЗГ	Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 21 дүгээр зүйлд заасны дагуу "Эссэнз саппайз" ХХК-аас түншлэлээр хэрэгжүүлэх төсөлд Арцсуурь-Нарийнсухайт-Шивээхүрэн чиглэлийн төмөр замын төслийг санаачлан ТЭЗҮС боловсруулан ирүүлсэн бөгөөд Төмөр зам, далайн тээврийн бодлого зохицуулалтын газраас зөвлөмж хүргүүлсэн. Тус ТЭЗҮ-ийг Зам, тээврийн хөгжлийн яамны ШУТЗ-ийн хурлаар хэлэлцүүлсэн. Төслийг санаачлан хэрэгжүүлэх саналыг, салбарын яамны ЭЗХЯ-нд хүргүүлсэн бөгөөд Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн дагуу СЯ-нд бүрэн шинжилгээ хийлгэх, санал дүгнэлт гаргуулахаар хүргүүлээд байна. ЭЗХЯ бүрэн шинжилгээ хийх төслийн багийг байгуулахаар ажиллаж байна. ЗТЯ-ны 2024.09.13-ны өдрийн 03/669 дугаартай албан бичгээр төслийн багт орж ажиллах ажилтан нарын нэрсийг хүргүүлсэн. ЭЗХЯ-ны ТНБД-ын 2024.10.30-ны өдрийн А/264 дугаар тушаалаар тус чиглэлийн төмөр замын төсөлд бүрэн шинжилгээ хийх "Төслийн баг байгуулах тухай" тушаал гарсан. Тус төслийн багт Өмнөговь, Баянхонгор, Говь-Алтай, Увс,



ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ

				Завхан аймгуудын төлөөлөл болон ЗТЯ, ЭЗХЯ, ЭЗХЯ-ны дэргэдэх Төр, хувийн хэвшлийн түншлэлийн төв ТӨААТҮГ-ын төлөөллөөс бүрдсэн 10 хүний бүрэлдэхүүнтэйгээр ажиллаж байна. Тус төслийн багийн хурлууд 2024.11.06, 2024.11.27-ны өдрүүдэд болсон. Дараагийн хурал 2024.12.20-нд хийхээр төлөвлөвлөн ажиллаж байна.
2.12	Улаанбаатар-Хархорин чиглэлийн төмөр замын техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах	Жилийн эцсийн байдлаар: ТЭЗҮ-ийг ШУТЗ-өөр хэлэлцүүлнэ.	ТЗДТБЗГ	Улаанбаатар-Хархорин чиглэлийн төмөр замын техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах ажлын даалгаврыг 2024 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр батлуулж "Монголын төмөр зам" ТӨХК-д хүргүүлсэн. МТЗ ТӨХК-ийн 2024.03.19-ний 01/506 дугаартай албан бичгээр Улаанбаатар-Хархорин чиглэлийн төмөр замын 3 трассын хувилбарыг боловсруулж ирүүлснийг холбогдох байгууллагуудын мэдээлэлтэй уялдуулан, санал авахаар ЗТХЯамны ТНБД-ын 2024.03.19-ний 03/1131 дугаартай албан бичгээр БХБЯ, БОАЖЯ, УУХҮЯ, ХНХЯ, БХЯ, ЭХЯ, ЭЗХЯам, Нийслэлийн засаг дарга, ГЗБГЗЗЕГ, "Шинэ хархорум" хотын бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргаа зэрэг 10 байгууллагад хүргүүлж, мэдээллийг авч "МТЗ" ТӨХК-д хүргүүлсэн. Төр хувийн хэвшлийн түншлэлийн тухайн хуулийн хүрээнд тухайн төслийг хэрэгжүүлэх бүтэц өөрчлөгдөж ТЭЗҮ-ийг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгэхээр болсон. 2024 оны төсвийн тухай хуульд туссан ЭЗХСайдын багцад 3 тэрбум төгрөг тусгасан. Улаанбаатар-Хархорин чиглэлийн төмөр замын техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах ажлын даалгаврыг 2024 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр батлуулж "Монголын төмөр зам" ТӨХК-д хүргүүлсэн. Улаанбаатар-Хархорин чиглэлийн хурдны төмөр замын ТЭЗҮ боловсруулах ажлыг "МТЗ" ТӨХК-тай Бүгд Найрамдах Солонгос Улсын Үндэсний төмөр замын газартай хамтран ажиллах санамж бичгийн хүрээнд хэрэгжүүлэхээр тохирсон. Солонгосын талаас төслийг хэрэгжүүлэх санхүүжилтийг шийдвэрлэсэн тухай мэдээлэл ирүүлээд байна. Төр хувийн хэвшлийн түншлэлийн тухайн хуулийн хүрээнд тухайн төслийг хэрэгжүүлэх бүтэц өөрчлөгдөж ТЭЗҮ-ийг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгэхээр болсон. 2025 оны төсөвт 30,8 тэрбум төгрөг тусгасан. 2024.06.18-ны өдөр "Монголын төмөр зам" ТӨХК болон "Солонгосын үндэсний төмөр зам" ТӨХК-тай харилцан ойлголцлын санамж бичиг байгуулсан. Уг санамж бичгийн дагуу талууд төмөр замын салбарт хамтран ажиллах, Тухайлбал: Улаанбаатар-Хархорин чиглэлийн төмөр замын техник, эдийн засгийн үндэслэлийг

				боловсруулах чиглэлээр хамтран ажиллахаар тохиролцсон.
3.16	Авто замын барилгын ажлын явцад замын хөдөлгөөний аюулгүй байдлын аудит хийх тогтолцоог бүрдүүлэх	Хагас жилийн байдлаар: Эрх зүйн орчныг бүрдүүлж, холбогдох журамд өөрчлөлт оруулна. Авто замын барилгын 5 төсөлд аудит хийнэ.	АТБЗГ	АХБ-ны техникийн туслалцааны төслөөр ISO39001:2012 Замын хөдөлгөөний аюулгүй байдлын менежментийн тогтолцоо шаардлага MNS ISO39001:2014 стандартыг замын хөдөлгөөнд оролцогчид хэрхэн дагаж мөрдөх талаар дотоод аудит бэлтгэх, хөндлөнгийн аудит бэлтгэх үе шаттай сургалтыг ЗТХЯ, АТҮТ ТӨҮГ, "G2G" сургалтын төвтэй хамтран зохион байгуулж 50 гаруй албан хаагч оролцсон. Дэлхийн Банкны санхүүжилтээр НЗДТГ-аас хэрэгжүүлж буй Улаанбаатар хотын тогтвортой авто зам, тээвэр төслийн хүрээнд Зам тээврийн ослын бүртгэл мэдээллийн платформ боловсруулах зөвлөх үйлчилгээг хэрэгжүүлэхээр төлөвлөгдсөн бөгөөд шалгарсан зөвлөхтэй гэрээ байгуулах шатанд явж байна. /TRL Technologies ОУ-ын байгууллага шалгарсан/. Энэхүү зөвлөх үйлчилгээ нь нийт 13 сарын хугацаанд хэрэгжих бөгөөд 2025 оны хоёрдугаар улиралд багтааж зам тээврийн ослыг бүртгэх, дүн шинжилгээ хийх цогц функцтэй цогц платформ хөгжүүлэн хүлээлгэн өгөхөөр төлөвлөсөн.
3.18	Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль болон Замын хөдөлгөөний дүрмийн хэрэгжилтэд хөндлөнгийн аудит хийж, эрх зүйн зохицуулалтыг сайжруулах	Хагас жилийн байдлаар: Хөндлөнгийн аудитын дүгнэлт, зөвлөмжид үндэслэн Замын хөдөлгөөний аюулгүй байдлын Үндэсний Зөвлөлөөс холбогдох шийдвэр гарсан байна.	АТБЗГ	Хууль зүй, дотоод хэргийн сайд, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2024 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн А/177, А/130 дугаар хамтарсан тушаалаар "Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрэм"-д нэмэлт, өөрчлөлт оруулах төслийг боловсруулах чиг үүрэг бүхий хамтарсан ажлын хэсгийг байгуулав. Ажлын хэсгээс дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах төслийг боловсруулж байна.
4.5	Ховд-Улаангом чиглэлийн 163 км хатуу хучилттай авто замын барилгын ажлыг эхлүүлэх	Жилийн эцсийн байдлаар: Барилгын ажлын гүйцэтгэлийг 20 хувьд хүргэнэ.	АЗБЗГ	Ховд-Улаангом чиглэлийн 163 км хатуу хучилттай авто замын барилгын ажлын гүйцэтгэчийг сонгон шалгаруулах тендерийг Төрийн худалдан авах ажиллагааны газраас зохион байгуулж байна. Азийн хөгжлийн банкны журмын дагуу тендерийг 45 хоног нээлттэй байршуулж 2024 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр нээсэн. Нээлтэд 22 компанийн 53 оролцогчийн санал ирсэн. Азийн хөгжлийн банкны Худалдан авах ажиллагааны журмын дагуу үнэлгээг 90 хоногт үнэлж тайланг хүргүүлсэн. Тендер шалгаруулалтад ирсэн материалуудыг дахин үнэлж шаардлагад нийцсэн тайланг ирүүлэхийг Азийн хөгжлийн банкнаас шаардсан тул 2025 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийг хүртэл тендерийн хүчинтэй хугацааг сунгаад байна.



ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ

4.12	Баяндалай-Гурвантэс чиглэлийн 80 км хатуу хучилттай авто замын барилгын ажлыг эхлүүлэх	Жилийн эцсийн байдлаар: 10 км авто замын барилгын ажлын гүйцэтгэлийг 40 хувьд хүргэнэ.	АЗБЗГ	Баяндалай-Гурвантэс чиглэлийн 80 км хатуу хучилттай авто замын барилгын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ТХААГ-аас өөрчлөлтийн хүсэлт гаргасан. Зураг төслийг 02.02-ны өдөр ТХААГ-т хүргүүлсэн. Баяндалай-Гурвантэс чиглэлийн 80 км хатуу хучилттай авто замын барилгын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг зарласан.
4.25	Хилийн 5 тусгай зориулалтын хатуу хучилттай авто замаар холбох ажлыг үргэлжлүүлэх	Жилийн эцсийн байдлаар: Тавантолгой-Манлай-Ханги чиглэлийн авто замыг байнгын ашиглалтад оруулна. Тавантолгой-Гашуунсухайт авто замын барилгын ажлын гүйцэтгэлийг 75 хувьд, "Хашаатын цав" нүүрсний уурхайгаас Хавиргын боомт хүртэлх авто замын барилгын ажлын гүйцэтгэлийг 50 хувьд, "Эрзэн толгой" нүүрсний уурхайгаас Бичигтийн боомтын авто замын барилгын ажлын гүйцэтгэлийг 15 хувьд тус тус хүргэнэ.	АЗБЗГ	Концессын тухай хууль 2023.12.31-ний өдрөөс хүчингүй болж, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль 2024.01.01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн. Мөн Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийг дагаж мөрдөж журмын тухай хуулийн дагуу концессын гэрээ байгуулагдаагүй, гарын үсэг зурагдаагүй төслүүдийг Концессын хуулийн хүрээнд цааш үргэлжлүүлэх боломжгүй нөхцөл байдал үүссэн.
5.9	"Чингис хаан" олон улсын нисэх буудалд транзит зочид буудал, шатахуун хангамжийн байгууламж байгуулах ажлыг эхлүүлэх	Жилийн эцсийн байдлаар: Барилгын ажлын гүйцэтгэлийг 50 хувьд хүргэнэ.	ИНБЗГ	Транзит зочид буудал: ЗТЯ-ны ИНБЗГ-ын дарга, ИНЕГ-ын дарга, "НУБИЭ" ХХК-ийн гүйцэтгэх захирал, Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал ТӨХХК-ийн гүйцэтгэх захирал нар 2024.10.29-ний өдөр "Чингис Хаан" ОУНБ-д уулзалт зохион байгуулж тулгамдсан асуудлуудыг хэлэлцэн, нисэх буудал орчимын боломжит газрууд дээр ажиллаж агаарын тээврийн зорчигчдод зориулсан транзит зочид буудал байгуулах байршлыг нисэх буудлын баруун хойно буюу хурдны замын урд байрлах 27Б талбарыг байхаар шийдвэрлэсэн. транзит зочид буудлын ажлын даалгаврыг #4-ийг 2024 оны 03 дугаар сарын 18-ний өдөр Зам,



ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ

				тээврийн хөгжлийн яамны (хуучин нэрээр) Төрийн нарийн бичгийн даргаар батлуулсан. 2024 оны 11 дүгээр сард холбогдох ажлын даалгаврын хүрээнд судалгаа боловсруулсан. Транзит зочид буудал байгуулах боломжийг судлах талаар Ажлын хэсэг байгуулахаар ИНЕГ, "МИАТ" ТӨХК, "НУБИЭ" ХХК, "ХХНОБ" ХХК-аас Зам, тээврийн яамны 5а/1583 тоот албан бичгээр Ажлын хэсэгт орж ажиллах албан хаагчдын нэрсийг авч байна. Шатахуун хангамжийн байгууламж: Ажлын даалгаврыг боловсруулж, ТНБД-р батлуулсан (2024.03.18-ны 03). "Чингис хаан" ОУНБ-ын нэг талаас УТХ-ний газар, нөгөө талаас концессын талбайд "Агаарын хөлгийн Жет А-1 төрлийн шатахууны агуулах"-ын зориулалтаар ашиглуулахаар 62а, 62б, 62в-р 3 нэгж талбар газрын асуудлыг ЭЗХЯ, ИНЕГ, ТА-ын ЗДТГ, "НУБИА" ХХК-тай харилцан зөвшилцөж, шийдвэрлэсэн. 62а-р талбарыг "Эрчис Ойл" ТӨХХК-д төсөвт байгууллагын тусгай хэрэгцээнд ашиглуулахаар тус яамнаас ТАЗДТГ-т саналаа хүргүүлсэн, тэр дагуу тус компаниас холбогдох судалгааг хийж байна. (2024 оны 03/1668, 03/779, 03/1233); 62б, 62в-р талбарыг зориулалтын дагуу ашиглуулахаар тус яамнаас хүргүүлсэн саналын хүрээнд ТА-ийн Сэргэлэн сумын ЗД-ын 2024.10.25-ны өдрийн А/1022-р захирамжаар холбогдох дуудлага худалдааг зохион байгуулж байгаа болно. Тухайлбал бүртгэл 2024.12.03-ны өдөр эхлэн 2024.12.09-ний өдөр дуусаж, 2024.12.10-ны өдөр үнийн санал авна. Хоёр компани оролцох хүсэлт ирүүлснийг ТА-ын ГХБХБГ-т хүргүүлсэн. (2024.12.02-ны 03/1977, 03/1978)
6.5	Дорноговь аймгийн Замын-Үүд сумын "Бүс нутгийн логикийн төв"-ийг түшиглэн хуурай боомт байгуулах техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах	Жилийн эцсийн байдлаар: ТЭЗҮ, зураг төслийг ШУТЗ-өөр хэлэлцүүлнэ.	ТЗДТБЗГ	2024 оны 08 дугаар сарын 08-ны өдөр ТЗДТБЗГ, ДАУЗТХ Азийн хөгжлийн банкны төлөөлөгчидтэй цахим уулзалт хийх үеэрээ "Замын-Үүд хуурай боомт"-ын ТЭЗҮ, зураг төсөл болон барилгын ажилд шаардлагатай санхүүжилтийг шийдвэрлэх хүсэлт тавьсан боловч АХБ-ны зүгээс урьдчилсан ТЭЗҮС хийж өгөх боломжтой тухайгаа илэрхийлсэн. ЗТЯ-ны БТГ-ын дарга Б.Артур, ДАУЗТХ-ийн дарга Д.Жавхлан нар Дэлхийн банкны тээврийн ахлах мэргэжилтэн Эдвард Биукес, Дэд бүтэц хариуцсан мэргэжилтэн А.Мөнхжаргал нартай 2024 оны 10 дугаар сард хийсэн уулзалтын үеэр "Замын-Үүд хуурай боомт"-ын ТЭЗҮ, зураг төсөл болон барилгын ажилд шаардлагатай санхүүжилтийг шийдвэрлэх хүсэлт тавьсан. Уулзалтын мөрөөр ЗТЯ-наас Дэлхийн банкинд холбогдох мэдээллүүдийг бэлтгэн өгсний дагуу Дэлхийн банк тодорхой санхүүжилт гаргаж болох талаараа эргэн мэдэгдсэн бөгөөд энэ талаар эцсийн байдлаар ярилцаж тохирохоор БТГ-ын дарга Б.Артур, ДАУЗТХ-ийн дарга Д.Жавхлан нар



ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ

				Дэлхийн банкны тээврийн ахлах мэргэжилтэн Эдвард Биукес, Дэд бүтэц хариуцсан мэргэжилтэн А.Мөнхжаргал нартай 2024 оны 12 дугаар сарын 06-ны өдөр уулзаж ТЭЗҮ, зураг төслийн санхүүжилтийг Дэлхийн банкны буцалтгүй тусламжаар гүйцэтгэхээр тохирсон. "Замын-Үүд хуурай боомт" байгуулах техник эдийн засгийн үндэслэл боловсруулах ажлын суурь судалгаа боловсруулах гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж мэргэжлийн зөвлөх үйлчилгээний байгууллагын гүйцэтгэсэн тайлан гарсан.
9.2	Зам, тээврийн салбарын хүний нөөцийг хөгжүүлэх төлөвлөгөөг батлуулах	Жилийн эцсийн байдлаар: Төлөвлөгөөний 2024 оны хэрэгжилтийг 90-ээс доошгүй хувьд хүргэнэ.	БТГ	Салбарын хүний нөөцийн 2024-2030 он хүртэл хөгжүүлэх төлөвлөгөөний төслийг боловсруулан, мэргэжлийн боловсрол, сургалтын дэд салбар зөвлөлүүдийг хуралдуулахаар бэлтгэл ажлыг хийж байна.
9.10	Шинжлэх ухаан, технологийн их сургуультай хамтран зам, тээврийн салбарын судалгаа, шинжилгээний төвийг байгуулах бэлтгэл ажлыг эхлүүлэх	Жилийн эцсийн байдлаар: Судалгаа, шинжилгээний төвийг байгуулах бэлтгэл ажлыг эхлүүлнэ.	БТГ	Зам, тээврийн салбарын судалгаа, шинжилгээний төвийг байгуулах ажлын хүрээнд бусад улс орны туршлага, эрх зүйн орчны талаар судалгаа хийсэн. Энэ талаар БШУЯ-наас шинээр боловсруулж байгаа "Шинжлэх ухаан технологийн тухай" хуулийн төсөлд санхүүгийн эх үүсвэр, хөрөнгө оруулалтын талаар санал өгч ажилласан.
10.3	Зам, тээврийн салбарын бүтээн байгуулалт, үйл ажиллагаанд шинэ технологи, инноваци нэвтрүүлэх туршилт, судалгаа хийх	Жилийн эцсийн байдлаар: Салбарын бүтээн байгуулалтын төслийн явцыг зайнаас цахимаар хянаж төслийн удирдлагын програмд мэдээлэл оруулж туршсан байна. Олон улс, улсын чанартай авто замын дагуух тээврийн дэд бүтцийн мэдээллийг оруулна.	БТГ	Яамны Б байрны 1 дүгээр давхарт засвар хийж Зам, тээврийн салбарын цахим үйлчилгээний "eRThub" төв байгуулж ашиглалтад оруулах хөрөнгө оруулагч аж ахуйн нэгжүүдийг хамтран ажиллах урилгыг 2 удаа яамны цахим хуудсанд зарласан. https://mrt.d.gov.mn/l/3915 Мөн сонгон шалгаруулалтыг хийх ажлын хэсгийг ТНБД-ын 2024 оны А/28 дугаар тушаалаар байгуулсан. Яамны өргөтгөл Б байрны тухай хэсэгт засвар хийж хамтран ажиллах хувийн хэвшил материал ирүүлээгүй тул яам дотоод бололцоогоороо бүх тоног төхөөрөмжүүдээ аваад байна. Мөн НҮБХХ-т хандан албан бичгээр хүсэлт гаргаад байна. Зам, тээврийн салбарын үйлчилгээг цахимжуулах ажлын хүрээнд салбарын цахим үйлчилгээг гар утаснаас авах хувилбарт шилжүүлэн иргэд, олон нийт, харилцагчид зам, тээврийн салбарын салбарын AutoBox, SmartCar, e-Logistic, UBSmartBus, TeeverZuuch, TapaTrip, PapaLogistic, AbaTaxi, UbCab, ToGo, UBParking, MIAT-Airlines, Nisleg, UBTZTicket, E-Normative, AutoZam, iMap, NaviMarket, GeoNet зэрэг 30 гаруй аппликейшн ашиглалтад бүрэн оруулж,



ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ

				чирэгдэлгүй, түргэн шуурхай үйлчилгээ авч байна.
			АЗБЗГ	Шинэ техник, технологи, инновацын бүтээлийг хүлээн авч, судлах ажил хийгдэж байна.
			ТЗДТБЗГ	Шинэ техник, технологи, инновацын бүтээлийг хүлээн авч, судлах ажил хийгдэж байна. 3-р сардаа багтаан дүгнэж үр ашигтай инновацийн төслийг шалгаруулна.
50 хувийн хэрэгжилттэй арга хэмжээ				
2.2	Ханги-Мандал хилийн боомтын хил дамнасан холболтын төмөр замын барилгын ажлыг эхлүүлэх бэлтгэл ажлыг хангах	Жилийн эцсийн байдлаар: Монгол, Хятадын хилийн Ханги-Мандал боомтыг 2004 оны "Монгол, Хятадын хилийн боомт, тэдгээрийн дэглэмийн тухай Засгийн хоорондын хэлэлцээр"-т нэмж тусгах	ТЗДТБЗГ	Монгол улсын Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн А/162 дугаар тушаалаар "Монгол, Хятадын хилийн Ханги-Мандал боомтыг "Монгол, Хятадын хилийн боомт, тэдгээрийн дэглэмийн тухай Засгийн хоорондын хэлэлцээр"-т нэмж тусгах талаар Хятадын талтай хийж буй хэлэлцээг эрчимжүүлэх, төмөр замаар тээвэрлэх уул уурхайн бүтээгдэхүүн, ачаа тээврийн хэмжээ, эдийн засгийн үр ашгийг судлах чиг үүрэг бүхий Ажлыг хэсэг"-ийг байгуулсан. Судалгааны ажил хийгдэж байна.
2.3	Ханги-Номгон-Хөшигийн хөндий Сүхбаатар чиглэлийн хоёр дахь төмөр замын барилгын ажлыг эхлүүлэх бэлтгэл ажил хангах	Жилийн эцсийн байдлаар: Оросын талтай хэлэлцэж тохиролцсон байна.	ТЗДТБЗГ	Ханги-Номгон-Хөшигийн хөндий-Сүхбаатар чиглэлийн хоёр дахь төмөр замын барилгын ажлыг эхлүүлэх зорилгоор "Монголын төмөр зам" ТӨХК-ийн дэргэд төслийн нэгж байгуулан, холбогдох судалгааг хийж байна. Түүнчлэн 2024 оны 11 дүгээр сарын 20-22-ны өдрүүдэд ОХУ-ын Москва хотноо зохион байгуулагдах "Тээврийн долоо хоног" арга хэмжээнд Зам, тээврийн сайд Б.Дэлгэрсайхан оролцох бөгөөд энэ үеэрээ ОХУ-ын Тээврийн сайд болон "Оросын төмөр замууд" НХН-ийн удирдлагуудтай уулзалт хийж, Ханги-Номгон-Хөшигийн хөндий-Сүхбаатар чиглэлийн хоёр дахь төмөр замын барилгын ажлыг эхлүүлэх асуудлаар санал солилцоно.
2.5	Гашуунсухайт-Ганцмод боомтын хил холболтын 18.9 км төмөр замын барилгын ажлыг эхлүүлэх	Жилийн эцсийн байдлаар: Барилгын ажлын гүйцэтгэлийг 40 хувьд хүргэнэ.	ТЗДТБЗГ	Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын "Чиг тогтоох тухай" асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн 2024.02.14-ний өдрийн 58 дугаар тогтоолоор батлуулсан. Барилгын ажлын явцын талаар 2024.03.13-ны өдрийн 10 дугаар хуралдаанд танилцуулан тэмдэглэл гарсан. "Тавантолгой төмөр зам" ХХК болон "Хятадын зураг төслийн групп" компани нар 2023.05.26-ны өдөр гэрээ байгуулан Гашуунсухайт-Ганцмод хил дамнасан төмөр замын ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах ажлыг гүйцэтгэж 2023 оны 10 дугаар сарын 18-ны өдөр Зам, тээврийн хөгжлийн яамны Шинжлэх ухаан, технологийн зөвлөлөөр хэлэлцүүлэн дэмжигдсэн. Засгийн газрын 2024 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 58 дугаар тогтоолоор Гашуунсухайт-Ганцмод боомтын хил

				дамнасан өргөн, нарийн царигийн төмөр замын шугамын чигийг тогтоосон. Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн "Шинэ сэргэлтийн бодлого батлах тухай" 106 дугаар тогтоол, 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн "1955 оны Монгол-Хятадын хилийн төмөр замын хэлэлцээр болон Гашуунсухайт-Ганцмод хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын ажилтай холбоотойгоор авах арга хэмжээний тухай" 68 дугаар тогтоол, Засгийн газрын 2023 оны 08 дугаар сарын 23-ны өдрийн 310 дугаар тогтоол зэрэг шийдвэрүүдийг тус тус үндэслэн, Монгол, Хятадын "Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын гүүрийг хамтран барих тухай Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр"-ийг 2024 оны 04 дүгээр сарын 02-ны өдөр байгуулсан. Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын инженерийн нарийвчилсан зураг төслийг боловсруулж, магадлуулахаар хүргүүлээд байгаа бөгөөд нийт зураг төслийн гүйцэтгэл 99 хувьтай байна. "Тавантолгой төмөр зам" ХХК нь БНХАУ-ын "Чайна энерги Ганцмод төмөр замын хөрөнгө оруулалт" ХК-тай Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтыг хамтран барих тухай хэлэлцээрийг байгуулахаар МУ-ын ЕС-ын 2024 оны 09 дүгээр сарын 16-ны өдрийн 59 дугаар захирамжаар байгуулсан ажлын хэсэг ажиллаж байна.
2.8	Сайншанд-Баруун-Урт-Хөөт чиглэлийн 433 км төмөр замын төслийг эхлүүлэх бэлтгэл ажлыг хангах	Жилийн эцсийн байдлаар: "Зураг төсөл боловсруулах-барих-ашиглах-шилжүүлэх" концессын төрлөөр төслийг хэрэгжүүлэх хөрөнгө оруулагчийг сонгож, гэрээ байгуулна.	ТЗДТБЗГ	Төр, хувийн хэвшлийн түншлэлээр Сайншанд-Баруун-Урт-Хөөт чиглэлийн төмөр замын төсөлд оролцох гадаад, дотоодын аж ахуй нэгжээс хүсэлт ирж байна. ЭЗХЯ-д уламжлаад байна. Тавантолгой-Нарийнсухайт, Сайншанд-Баруун-Урт-Хөөт чиглэлийн төмөр замын ТЭЗҮС-г Монгол Улсын СЯ, ЗТХЯ болон БНСУ-ын Газар, дэд бүтэц, тээврийн яам хооронд байгуулсан санамж бичиг байгуулж "Монгол Улсын төмөр замын хөгжлийн стратеги Зүүн Азийн Төмөр замын нийгэмлэг (EARC)-ийн үүсгэн байгуулалттай уялдах нь" төслийн хүрээнд Солонгосын KOICA, KORAIL зэрэг байгууллагууд хамтран боловсруулсан.
2.14	Хилийн Арцсуурь-Цагаантолгой төмөр замын боомт байгуулах хэлэлцээг эхлүүлэх	Жилийн эцсийн байдлаар: Хэлэлцээрт нэмэлт оруулах төслийг Оросын талд хүргүүлнэ.	ТЗДТБЗГ	Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны Монгол-Оросын Засгийн газар хоорондын комиссын Бүс нутаг, хил орчмын хамтын ажиллагааны дэд комиссын 16 дугаар хуралдааны протоколд "Монголын тал төмөр замын баруун босоо коридор буюу Арцсуурь-Нарийнсухайт-Шивээхүрэн төслийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлын хүрээнд Арцсуурь-Цагаантолгой төмөр замын шалган нэвтрүүлэх шинэ боомт байгуулах саналыг

				дахин илэрхийлэв. Оросын тал уг асуудлыг судлан, 2025 онд багтаан шийдвэрлэхээ илэрхийлэв." Саналыг тусгуулахаар ЗТЯ-ны Гадаад хамтын ажиллагааны хэлтсээр дамжуулан Гадаад харилцааны яаманд хүргүүлсэн.
3.4	Хилийн боомтод ачаа тээврийн терминал байгуулах	Жилийн эцсийн байдлаар: Хавирга, Булган боомтын ачаа тээврийн терминалын барилгын ажлын гүйцэтгэлийг 30 хувьд хүргэнэ.	АТБЗГ	Булган хилийн боомтын ачаа, зорчигч тээврийн терминалыг сайжруулах ажлын хүрээнд Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлээр боомтын барилга байгууламж, инженерийн дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлээд байна. Төслүүдийн хүрээнд одоо байгаа боомтын хүчин чадал 2-3 дахин нэмэгдэнэ. Мөн Булган хилийн боомтын ТЭЗҮ, зураг төслийн ажлыг дуусгаж, бүтээн байгуулалтын ажил хийгдэж байна. Хавирга боомтын орчимд ачаа тээврийн терминал байгуулах зорилгоор "Ти Ар Эн Эс" ХХК нь газар ашиглах гэрээг Хилийн боомтын захиргаатай байгуулсан. Тус компани нь ачаа тээврийн терминалын талбайн газар шороо, пүү суурилуулах ажлыг хийж дуусгаад байна. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд Алтанбулаг тээвэр логиستيкийн төв байгуулахаар ТЭЗҮ болон урьдчилсан үнэлгээг үнэлгээг хийж, хянан батлуулахаар Эдийн засаг, хөгжлийн яаманд 2024 оны 02/2840 тоот албан бичгээр хүргүүлэв.
3.12	Ашиглалтаас хасагдсан автомашины хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэрийг байгуулах	Жилийн эцсийн байдлаар: Ашиглалтаас хасагдсан тээврийн хэрэгслээс үүдэлтэй аюултай хог хаягдлыг цуглуулах 5 цэг байгуулна.	АТБЗГ	Зам, тээврийн хөгжлийн яамнаас автотээврийн хэрэгслийн ашиглалтын явцад үүссэн шингэн болон хатуу хог хаягдлыг боловсруулах үйлдвэр байгуулах техник эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах, үйлдвэр байгуулж ашиглах саналыг дотоод, гадаадын аж ахуйн нэгжид санал болгож байна. Японы Улсын Жайка байгууллага, Туркийн Тика байгууллагын 2024 онд Монгол Улсад хэрэгжүүлэх төсөлд тусган хамтран ажиллах саналыг хүргүүлсэн. Жайка байгууллага Монголын талын холбогдох байгууллагын дэмжлэг авч Японы Засгийн газарт уламжилж ажиллахаа мэдэгдсэн. Зам, тээврийн хог хаягдлын хэмжээ, эрх зүйн баримт бичгүүд судалж, судалгаа хийх, авто рейсаклийн үйл ажиллагаа явуулах урьдчилсан техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах зорилгоор "АВТО МОТО НИЙГЭМЛЭГ" ТББ, ЯПОН УЛСЫН "ТОУОТОМИ" ХХК-тай зам, тээврийн салбарын хог хаягдлын менежментийг сайжруулах чиглэлээр хамтран ажиллах санамж бичиг байгуулж байна. "Электрокем Монгол" ХХК-д ашиглалтаас хасагдсан автомашины шингэн хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэр байгуулж ажиллах саналыг хүргүүлсэн. Тус компани судалгааны ажлаа эхлүүлээд байна.
3.15	Тусгай зориулалтын	Хагас жилийн байдлаар:	АТБЗГ	Уул уурхай, хөдөөгийн замын онцлог сэдвээр ТЦА, ЗТХТ, АТҮТ ЗТХЯ, УУХҮЯ зэрэг

ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ

	авто замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах эрх зүйн орчныг бүрдүүлэх	Холбогдох судалгаа хийж, баримт бичгийн төслийг боловсруулна. Жилийн эцсийн байдлаар: Тусгай зориулалтын авто замын хөдөлгөөнийг зохицуулах холбогдох баримт бичгийг батлуулна.		байгууллагуудын хамтарсан хэлэлцүүлгийг 2024 оны 03 дугаар сарын 13-нд зохион байгуулсан. Уг хэлэлцүүлгээс гарсан зөвлөмжийн дагуу Хууль зүй, дотоод хэргийн сайд, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2024 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн А/177, А/130 дугаарт хамтарсан тушаалаар "Монгол Улсын Замын хөдөлгөөнд дүрэм"-д нэмэлт, өөрчлөлт оруулах төслийг боловсруулах чиг үүрэг бүхий хамтарсан ажлын хэсгийг байгуулсан. Ажлын хэсэг холбогдох баримт бичгийг боловсруулсан.
3.17	Олон улсын болон орон нутгийн чанартай авто замд 1-2 чиглэлд замын хөдөлгөөний аюулгүй байдлын үнэлгээ хийх	Жилийн эцсийн байдлаар: Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль болон Замын хөдөлгөөний дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулж, батлуулна.	АТБЗГ	Тээврийн цагдаагийн алба МИС-тай хамтарч улсын чанартай Лүн – Эрдэнэсант чиглэлд хөдөлгөөний аюулгүй байдалд үнэлгээ хийх ажлын хэсэг бүрэлдэхүүнийг томилох тушаал батлагдсан. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын үнэлгээ хийж эхэлсэн.
3.21	Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах арга хэмжээг зохион байгуулах	Жилийн эцсийн байдлаар: Замын хөдөлгөөний аюулгүй байдал" сургалтын төв байгуулах ажлыг эхлүүлнэ. Авто замын дагуух үйлчилгээний цогцолборт 10-аас доошгүй эмнэлгийн анхны тусламжийн цэг байгуулна. Хүүхэд, залуучуудын замын хөдөлгөөний сургалтын 5 төв байгуулна.	АТБЗГ	Хүүхдийн төлөө сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх "Хүүхдэд зориулсан бүтээн байгуулалтын төсөл"-д тус албаны Урьдчилан сэргийлэх хэлтсээс "Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд "Авто зам, замын байгууламж бүхий хүүхдийн замын хөдөлгөөний танин мэдэхүйн талбай" байгуулах төслийг 2022 онд бэлтгэн хүргүүлснээр шалгарч, Хөдөлмөр, нийгэм хамгааллын сайдын багцын 2023 оны Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний саналд төсөв (443,415,586,0)-ийг тусгасан. Улмаар Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын даргын 2023 оны 11 дүгээр 2023 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн А/174 дугаар тушаалаар Үнэлгээний хороог байгуулснаар өнөөдрийг хүртэл төслийг гүйцэтгэгч байгууллагыг сонгон шалгаруулах ажлыг 3 удаа зохион байгуулаад байгаа бөгөөд төслийг бичих үеийн зардлаас зах зээлийн бодит өртөг өссөнтэй холбоотой байгууллагуудаас өнөөдрийг хүртэл материал ирүүлээгүй байна. НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тусгай элч Жан Тодт Монгол Улсад Айлчилж 2024.03.28-ны өдөр ГХЯ-ны хурлын "Зөвшилцөл" танхимд хэвлэлийн бага хурал хийж, "АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТӨЛӨӨ ҮГЭЭ ХЭЛЦГЭЭ" уриатай Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах дэлхий нийтийг

				хамарсан компанит аянд Монгол улс нэгдсэнээ албан ёсоор зарлалаа. Монгол Улсын замын хөдөлгөөний аюулгүй байдлын асуудал хариуцсан "Тусгай элч"-ээр Моод" контентын захирал, Цэцэгчлэгч төслийг санаачлан хэрэгжүүлэгч Б.Болд, Аюулгүй Байдал Судлалын Монгол Эрдэмтдийн Нийгэмлэгийн гүйцэтгэх захирал, Монголын Бартаат Замын Авто Спортын Холбооны ерөнхийлөгч Л.Батсайхан, Монгол телевизэд "Хар энтертайнмент" студид найруулагч, УДЭТ-ын жүжигчин М. Түвшинхүү, Автохим ХХК-ны захирал, "Монголын автомастеруудын холбоо"-ноос зохион байгуулагддаг авто уралдааны жил бүрийн ивээн тэтгэгч, МУ-ын зөвлөх инженер Д. Лхагвасүрэн зэрэг нийгэмд нэр нөлөө бүхий дээрх хүмүүсийг томилсоноо зарлалаа. Дугуй ширээний уулзалт ярилцлага өрнүүлж НҮБ-ын ЗХАБ-ын тусагай элч, суурин зохицуулагч, Хүүхдийн сан, Дэлхийн ЭМБ, ЗХАБҮЗ-ийн гишүүд, ГХЯ, Соёлын яам, ЗТХЯ зэрэг төрийн болон төрийн бус байгууллага иргэдийн төлөөлөл нийт 70 гаруй хүн оролцлоо.
4.2	Чойр-Мандалговь-Арвайхээр чиглэлийн хэвтээ тэнхлэгийн авто зам, Мандалговь-Чойр чиглэлийн хатуу хучилттай авто замын эхний үе шатны барилгын ажлыг эхлүүлэх	Жилийн эцсийн байдлаар: 9.7 км хатуу хучилттай авто замын барилгын ажлын гүйцэтгэлийг 45 хувьд хүргэнэ.	АЗБЗГ	Төрийн худалдан авах ажиллагааны газар /цаашид ТХААГ гэх/-аас тендерийг 2024.05.08-ны өдөр зарлаж, 2024.05.30-нд тендерийг нээсэн. Шинээр 2024.09.16-ны өдрийн байдлаар зарлаж, тус авто замын гүйцэтгэгчээр-"Мянган тэмүүлэл" ХХК тендерт шалгарч зам тээврийн яамтай 2024 оны 10 дугаар сарын 23-ны өдөр гэрээ байгуулан 2024 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр барилгын ажлыг эхлүүлсэн. Гүйцэтгэгч компани хөрс хуулалт, нүүлгэн шилжүүлэлт, ухмалын ажлыг хийж гүйцэтгэсэн. Барилгын ажлын гүйцэтгэл 2024 онд төлөвлөсөн ажил 10 хувь, нийт ажлын хувь 5 хувь хийгдсэн.
4.4	Алтай-Улиастай чиглэлийн 100 км хатуу хучилттай авто замын барилгын ажлыг эхлүүлэх	Жилийн эцсийн байдлаар: 40 км авто замын барилгын ажлын гүйцэтгэлийг 15 хувьд хүргэнэ. 60 км авто замын зураг төслийг дуусгана.	АЗБЗГ	Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг ТХААГ-аас зохион байгуулсан. Тендерийг журмын дагуу 45 хоног нээлттэй байршуулж 2024.05.01-ны өдөр нээсэн. Нээлтэд 10 ААНБ-ын 11 оролцогчийн санал ирсэн. АХБ-ны ХАА-ны журмын дагуу үнэлгээг 90 хоногт үнэлж тайланг хүргүүлж АХБ-с 2024.09.26-ны өдөр зөвшөөрөл ирүүлсэн. Холбогдох зөвшөөрлийн дагуу шалгарсан гүйцэтгэгчтэй гэрээ байгуулах мэдэгдлийг хүргүүлж гэрээнд 2024.12.05-ны өдөр ТНБД гарын үсэг зуран баталгуулжснаар гэрээ хүчин төгөлдөр болсон. Батлагдсан гэрээний дагуу гүйцэтгэгчтэй ажил гүйцэтгэх график төлөвлөгөө боловсруулан батлуулахаар ТХН болон бусад холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж байна. 60 км авто замын



ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ

				зураг төсөл боловсруулах гүйцэтгэгчтэй компанитай 2024.10.14-нд гэрээ байгуулан ажлыг эхлүүлсэн.
4.11	Жаргалтхаан-Өмнөдэлгэр чиглэлийн авто замаас Биндэр чиглэлийн 127.5 км авто замын барилгын ажлыг эхлүүлэх	Жилийн эцсийн байдлаар: Барилгын ажлын гүйцэтгэлийг 10 хувьд хүргэнэ.	АЗБЗГ	2024 оны 4-р улирлын байдлаар тус авто замын Багц 3-ын тендерийг ТХААГ-аас 3 удаа зарласан боловч гүйцэтгэгч шалгараагүй тендер хүчингүй болсон. Тендерийг дахин зарлаж, гүйцэтгэгчээр "Хөвчийн зам" ХХК шалгарч, 2024 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр гэрээ байгуулах мэдэгдлийг өгсөн ба гэрээ байгуулагдах шатандаа явж байна. Тус авто замын гүйцэтгэгч сонгон шалгаруулах үйл ажиллагаа оройтсон тул гэрээний хэрэгжилтийг ханган ажиллах боломжгүй нөхцөл байдал үүссэн тул үнэлэх боломжгүй байна.
4.16	Улааннуур-Улаангом чиглэлийн хатуу хучилттай авто замын эхний үе шат 26.39 км авто замын барилгын ажлыг эхлүүлэх	Жилийн эцсийн байдлаар: Барилгын ажлын гүйцэтгэлийг 15 хувьд хүргэнэ.	АЗБЗГ	Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг ТХААГ-аас зохион байгуулан тендерийг 3 удаа зарласан. 2024.06.12-ны өдөр нээсэн. Тендерийг дахин зарлахаар болсон. Захиалагчид 2024.11.29-ний өдрийн А-1/4446 дугаартай албан бичгээр гэрээ байгуулах зөвлөмжийг ирүүлээд байна. Гүйцэтгэгчтэй гэрээ байгуулах ажил хийгдэж байна.
4.24	"Монгол Улсын тээврийн холболт ба логикийг сайжруулах төсөл"-ийн хүрээнд улсын чанартай авто зам болон төмөр бетон гүүрийн ээлжит болон их засварын ажлыг эхлүүлэх	Жилийн эцсийн байдлаар: Авто зам, гүүрийн их засварын ажлын гүйцэтгэлийг 40 хувьд хүргэнэ.	АЗБЗГ	Багц 1 хэсэг буюу Улаанбаатар-Өндөрхаан чиглэлийн 68 км авто замын их засварын ажил, Арвайхээр-Баянхонгор чиглэлийн 35 км авто замын их засварын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн 1 дүгээр үе шатыг амжилттай зохион байгуулж Дэлхийн банкнаас зөвшөөрөл аван 2 дугаар үе шатыг зарласан. 2024.12.16-ны өдөр нээнэ. Багц 2 буюу Улаанбаатар-Арвайхээр, Хархорин-Цэцэрлэг, Цэцэрлэг-Тосонцэнгэл чиглэлийн авто замын засварын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн 1 дүгээр үе шатыг амжилттай зохион байгуулж Дэлхийн банкнаас зөвшөөрөл аван 2 дугаар үе шатыг зарласан. 2025.01.08-ны өдөр нээнэ. Төслийн зөвлөх компанийг сонгон шалгаруулах тендерийг 2024.11.15-ны өдөр зарлаж богино жагсаалт үүсгэн Дэлхийн банкнаас зөвшөөрөл авсан. Богино жагсаалтад орсон зөвлөх компаниудын тендерийг 2024.12.27-ны өдөр нээнэ. Багц 3 дугаар хэсэг буюу Өндөрхаан-Чойбалсан чиглэлийн 50 км хатуу хучилттай авто замын шинэчлэлтийн ажлын тендерийн баримт бичгийг боловсруулан Дэлхийн банкнаас зөвшөөрөл авахаар хүргүүлсэн.
5.7	"Дэлүүнболдог", "Өндөрхаан", "Өлгий" нисэх буудлыг	Жилийн эцсийн байдлаар: "Өндөрхаан" нисэх буудлын зорчигч	ИНБЗГ	"Өндөрхаан": Төслийг гурван багц болгон зохион байгуулсан; Багц-1: ЗҮБ, байгууламжийн ажлын гүйцэтгэл 94.6 хувьтай үргэлжилж байна, 2024.12-р сард байнгын ашиглалтад хүлээн авна.



ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ

өргөтгөх, шинэчлэх ажлыг хэрэгжүүлэх	үйлчилгээний барилга, “Дэлүүнболдог” нисэх буудлын зорчигч үйлчилгээний барилгыг тус тус байнгын ашиглалтад хүлээн авна. “Өлгий” нисэх буудлын өргөтгөлийн барилгын ажлын гүйцэтгэлийг 30 хувьд хүргэнэ.	Багц-2: Агаарын хөлгийн хөөрч буух зурвас, перрон зогсоолын ажлын гүйцэтгэл 100 хувь буюу Улсын комиссын 2024 оны 13/01/24-р үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад хүлээн авсан. Багц-3: Газрын үйлчилгээний машин, чиргүүл, ачаа тээшний рентген, металл илрүүлэгч хаалга худалдан авах ажлын гүйцэтгэл 100 хувьтай дууссан. Мөн төслийг бүрэн дуусгахад шаардагдах МӨ Дүгнэлтээр баталгаажсан 1,162,760,923.00 төгрөгийн нэмэлт санхүүжилтийг шийдвэрлүүлэхээр СЯ- нд тухай бүрд (ЗТХ-ийн сайдын 2024 оны 01/151, 01/1817, 01/2039) хандаж, талуудын 2024.12.03-ны өдрийн уулзалтаар шийдвэрлүүлсэн. /100%/
		“Дэлүүнболдог”: Багц-1: Гүйцэтгэгч компани нь гэрээт ажлын тоо хэмжээг хийж гүйцэтгэсэн тул техникийн комисс ажиллуулах талаар хүсэлт (2024.12.03-ны өдрийн 115/24) ирүүлсэн. Энэ хүрээнд тус яамнаас техникийн комисс байгуулахаар тушаалын төслийг боловсруулсан, холбогдох газруудаас нэр авах (2024.12.04-ний 09/2002) шатанд байна. Багц-2: Гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалтыг 2024.03, 05, 09-р сард тус тус нийт 3 удаа зохион байгуулсан бөгөөд сүүлийн шалгаруулалт амжилттай болж тус яамнаас “Барилга Эрч” ХХК-тай 2024.09.19-ний өдрийн УТ2002800921/432-р гэрээг байгуулан, ажиллаж байна. /100%/
		Өлгий: Монгол Улсын Их Хурлын гишүүн Х.Баделхан, Т.Аубакир нараас Монгол Улсын ерөнхий сайдад хүргүүлсэн УИХ-03/771 тоот хүсэлтийн дагуу Зам, тээврийн хөгжлийн сайдын (хуучин нэрээр) 2024 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн “Эрх шилжүүлэх тухай” А/26 тоот тушаалаар Баян-Өлгий аймгийн Өлгий нисэх буудлын өргөтгөлийн барилгын ажлыг хэрэгжүүлэх, санхүүжүүлэх, хяналт тавих эрхийг Баян-Өлгий аймгийн Засаг даргад шилжүүлсэн. Гэвч ЗТХЯ/20240101099 дугаартай цахим тендерт оролцож шалгараагүй “Өлкө констракшн” ХХК-аас удаа дараа Сангийн яаманд гомдол хүргүүлсэн бөгөөд тус яам нь гомдлыг үндэслэлтэй гэж үзсэн 2024 оны 09 сарын 26-ны өдрийн 03/8038 тоот албан бичгийн ирүүлсэн. Иймд Зам, тээврийн сайдын 2024 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн А/213 тоот “Эрх шилжүүлэх тухай” тушаалаар Өлгий нисэх буудлын өргөтгөлийн барилгын ажлыг хэрэгжүүлэх, санхүүжүүлэх, хяналт тавих эрхийг Иргэний нисэхийн ерөнхий газарт шилжүүлсэн. Үнэлгээний хороо байгуулагдсан бөгөөд 2024 ондоо багтаан сонгон

				шалгаруулалт зарлахаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. /70%/
5.8	"Ховд", "Даланзадгад", "Мөрөн", "Чойбалсан" нисэх буудлын хүчин чадлыг нэмэгдүүлж, ашиглалтыг сайжруулах төслийг хэрэгжүүлэх	Жилийн эцсийн байдлаар: Нисэх буудлуудын мастер төлөвлөгөөний төслийг хянасан байна.	ИНБЗГ	ТХААГ нь Концессын тухай хуулийн үйлчлэлийн хугацаанд буюу 2023.12 сард төслүүдийн концесс олгох уралдаант шалгаруулалтыг зарласан (2023.12.28-2024.02.28) боловч Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль 2024.01.01-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр хэрэгжиж эхэлснээр шалгаруулалтыг түр зогсоосон. Тус газар нь уг асуудлаар шийдвэр гаргуулахаар ЗГХЭГ-т хандсан, Засгийн газрын хуралдаанаас эцсийн шийдвэр гарах талаар хариу мэдэгдсэн (2024.02.01-ний 01/471, 2024.02.06-ны А-1/556). Мөн тус яамнаас Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн дагуу төслийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангах хүрээнд ИНЕГ-т зохих чиглэл хүргүүлсэн, (2024.04.28-ны 02/1811, 2024.07.23-ны 09/3060) тэр дагуу тус газраас төсөв, урьдчилсан болон нарийвчилсан ТЭЗҮ боловсруулахад шаардагдах дунджаар 600 орчим сая төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлэхээр ажиллаж байна (2024.06.19-ний 04/1354, 2024.08.05-ны 02/1745). Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн дагуу төслийн саналаа ЭЗХЯ-нд хүргүүлээд байна. Түүнчлэн "Ховд", "Мөрөн", "Дэглий цагаан" нисэх буудлын хүчин чадлыг нэмэгдүүлж, ашиглалтыг сайжруулах төслийн ТЭЗҮ, зураг төслийн санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэж, тендер шалгаруулалтыг 2024 оны 11 сарын 15-ны өдөр зарласан. 1.4 тэрбум төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлэсэн.
5.12	Буйр нуур, Халх голын сав газар нутгийг аялал жуулчлалын чиглэлээр хөгжүүлэх, 4С нисэх буудал байгуулах боломжийг Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдтай хамтран судалж хөрөнгө оруулалтыг шийдвэрлэх	Жилийн эцсийн байдлаар: Санхүүжилтийн эх үүсвэрийг эрэлхийлнэ.	ИНБЗГ	ИНЕГ-аас Дорнод аймгийн Халхгол сумын орчимд Олон улсын иргэний нисэхийн байгууллагын шаардлагыг хангасан 4С хяналтын кодтой нисэх буудал барьж байгуулахад нийт 110.5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт шаардлагатай гэж тооцоолсон. Тус нисэх буудлын ТЭЗҮ, ажлын даалгаврыг боловсруулахад 2.5 тэрбум төгрөг шаардлагатай. 2025 оны улсын төсөвт ТЭЗҮ, ажлын даалгаврыг боловсруулан барилга угсралтын ажил эхлүүлэхээр 24.5 тэрбум төгрөг тусгагдсан боловч 2024.12.04-ний өдөр Ерөнхийлөгчийн шийдвэрээр төсвөөс хасагдсан.
6.3	БНХАУ-ын далайн боомтуудаас ачаа	Жилийн эцсийн байдлаар: Далайн боомтуудаас	ТЗДТБЗГ	БНХАУ-ын Далянь далайн боомтоор дамжуулан Монгол Улсын импортын автомашиныг тусгай зориулалтын автомашин болон галт тэргээр тээвэрлэх нөхцөл



ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ

	тээвэрлэлтийг г эхлүүлэх	ачаа тээвэрлэлтийг эхлүүлж, тогтворжуулна.		боломжийн талаарх холбогдох тооцоо судалгааг боловсруулсан. Тээвэрлэлтийн бэлтгэл ажлыг хангах ажлын хүрээнд Ляонин мужийн дэд захирагч Жин Гуовэй тэргүүтэй албан айлчлалын баг бүрэлдэхүүн 2024 оны 08 дугаар сарын 12-15-ны өдрүүдэд Монгол Улсад айлчлал хийсэн бөгөөд тус айлчлалын үеэр Далянь боомтоос Эрээн/Замын-Үүд чиглэлд ачаа тээвэрлэлт (автомашин)-ийг хөгжүүлэх, боомт дээрх ачаа тээвэрлэлтийг саадгүй зохион байгуулах талд нягт хамтарч ажиллах хүсэлтийг тавьсан ба Ляонин мужийн дэд захирагчийн зүгээс дэмжиж хамтарч ажиллахаа илэрхийлсэн. Тус айлчлалын хүрээнд Ляонин мужийн ардын засгийн газар болон Далянь хотын ардын засгийн газартай Далянь боомтоос тээвэрлэлт эхлүүлэх талаар санал солилцож ажиллаж байна. Мөн Ляонин мужийн худалдааны хэлтэстэй Далайн захиргааны байранд 2024 оны 09 дүгээр сарын 20-ны өдөр Далянь боомтоор дамжуулан автомашин задгайгаар тээвэрлэх ажлын талаар уулзалт хийж санал солилцсон. Туршилтын тээвэрлэлтийг эхлүүлэх ажлын хүрээнд холбогдох дотоодын мэргэжлийн байгууллагуудтай уулзалтуудыг зохион байгуулав. Үүнд: -2024.09.05-ны өдөр Замын-Үүд чөлөөт бүсийн одоо байгаа дэд бүтцийг ашиглалт болон цаашид хамтран ажиллах боломжийн талаар Замын-Үүд чөлөөт бүсийн захиргаатай санал солилцох уулзалт; -2024.09.18-ны өдөр МТЗНХ-ны гишүүн Монложистик ХХК, Туушин ХХК-тай автомашины тээвэрлэлтийн талаар санал солилцох уулзалт; -2024.09.19-ны өдөр ГЕГ-тай автомашин задгайгаар тээвэрлэхэд хориг саад байгаа эсэх талаар мэдээлэл авч, хамтарч ажиллах тухай уулзалт; Туршилтын тээврийг зохион байгуулах ажлын хүрээнд гурван талын уулзалт зохион байгуулах тухай МУ-аас БНХАУ-д суугаа ЭСЯ-д уламжлуулах тухай 2024.11.08-ны өдрийн 01/1590 тоот албан бичгийг ГХЯ-нд, ГЕГ-аар дамжуулан Хятадын Гаалийн байгууллагад хүсэлт хүргүүлэх тухай 2024.11.08-ны өдрийн 01/1591 тоот албан бичгийг СЯ-нд тус тус хүргүүлсэн. Далянь боомттой тохиролцоонд хүрсэн бөгөөд хилийн боомтоор нэвтрүүлэх асуудлыг 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн Хятадын Эрээн хотод зохион байгуулагдсан хоёр улсын хилийн байгууллагуудын комиссын хурлын хэлэлцэх асуудалд тусгуулан хэлэлцүүлж, холбогдох санал, зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж байна.
6.6	Хөшигийн хөндийд хуурай боомт	Жилийн эцсийн байдлаар:	ТЗДТБЗГ	“Хуурай боомтын тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр”-т тусгагдсан

ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ

	байгуулах нөхцөл байдлын үнэлгээ, судалгаа хийх	Нөхцөл байдлын үнэлгээ, судалгааг боловсруулж, шийдвэр гаргах түвшинд танилцуулна.		байршлуудад нөхцөл байдлын үнэлгээ хийх судалгааг боловсруулж, танилцуулсан.
7.3	Буйр нуурт улирлын чанартай усан замын боомт байгуулах техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах	Жилийн эцсийн байдлаар: Хөрөнгийг шийдвэрлэсний үндсэн дээр ТЭЗҮ, зураг төслийг боловсруулна.	ТЗДТБЗГ	Буйр нуурт улирлын чанартай усан замын боомт байгуулах ТЭЗҮ, зураг төсөл боловсруулахад шаардагдах хөрөнгийг улсын төсвийн хөрөнгөөр шийдвэрлүүлэхээр ЭЗХЯ-нд хандсан боловч шийдвэрлэгдээгүй. Буйр нуурт улирлын чанартай усан замын боомт байгуулах талаар холбогдох мэдээллийг авах зорилгоор дараах ажлыг хийж гүйцэтгэж байна. Үүнд: 1. Хилийн зурвастай холбоотой бүс нутагт холбогдох байгууламж барих боломжийн талаар эрх зүйн мэдээлэл авах зорилгоор хил хамгаалах Ерөнхий газраас холбогдох мэдээллийг хүлээн авч судлан ажиллаж байна. 2. Нуурын орчим үйл ажиллагаа явуулахад шаардагдах байгаль орчны нөлөөлөлтэй холбоотой мэдээллийг цуглуулан боловсруулж байна. - Буйр нуурт усан замын боомт байгуулах нөхцөл байдлын судалгаа боловсруулах худалдан авах ажиллагааны ажлын даалгаврыг бэлтгэн 2024 оны 04 сарын 25 өдөр батлуулсан. - Буйр нуурт усан замын боомт байгуулах нөхцөл байдлын судалгаа боловсруулах тендэрт шалгарсан аж ахуйн нэгжтэй шалгарсан 2024 оны 06 сарын 03 өдөр гэрээ байгуулсан. "Буйр нуурт усан замын боомт байгуулах хөгжлийн концепц боловсруулах судалгаа"-ны ажлын тайланг боловсруулсан. Мөн судалгааны ажлын талаарх танилцуулгыг Боомтын Сэргэлтийн Үндэсний Хорооны хүсэлтээр 2024 оны 10 дугаар сарын 03-ны өдөр, 11 дүгээр сарын 29-ний өдөр тус тус танилцуулж, санал солилцож ажилласан. "Буйр нуурт усан замын боомт байгуулах" ажлыг хэрэгжүүлэх хүрээнд холбогдох байгууллагуудын төлөөллийг оролцуулсан Ажлын хэсэг байгуулах тухай Зам, тээврийн сайдын 2024 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн А/259 дугаар тушаалаар байгуулсан.
8.3	Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлогын баримт бичигт өөрчлөлт оруулах	Жилийн эцсийн байдлаар: УИХ-ын шийдвэр гаргуулна.	ТЗДТБЗГ	Зам, тээврийн хөгжлийн сайдын 2023.12.12-ны А/326 дугаар тушаалаар Монгол Улсын хөгжлийн урт хугацааны бодлого "Алсын хараа-2050"-тай уялдуулан Улсын Их Хурлын 2010 оны 32 дугаар тогтоолоор баталсан "Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого"-д нэмэлт өөрчлөлт оруулах төсөл боловсруулах, экспортыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд шинээр төмөр замын сүлжээг өргөжүүлэх нөхцөл боломжийг



ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ

				судлах үүрэг бүхий Ажлын хэсэгт ажилласан бөгөөд төслийн танилцуулга, тайлан, УИХ-ын тогтоолын төсөл, Үзэл баримтлалын төсөл, танилцуулга бэлтгэн яамны удирдлагад танилцуулсан. Үүнтэй давхцан Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал шинэчлэгдэн боловсруулагдаж байгаатай холбоотой "Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого"-д нэмэлт өөрчлөлт оруулах төслөөс төмөр замын хэсгийг түүнтэй нийцүүлэн боловсруулсан бөгөөд УИХ-ын 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн 64 дүгээр тогтоолоор Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд төмөр замын бодлого тусгагдаж батлагдсан.
9.1.	Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүдийг хэрэгжүүлэхэд чиглэсэн зам, тээврийн салбарын төлөвлөгөөг боловсруулж, батлуулах	Жилийн эцсийн байдлаар: Зам, тээврийн салбарын 2024-2028 оны стратеги төлөвлөгөөг батлуулна. Яамны 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулах, яамны нэгж, харьяа байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний төслийг хянана. Хөгжлийн зорилтот хөтөлбөрүүдийг батлагдсан тохиолдолд уг хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг батлуулна.	БТГ	Монгол Улсын 2024 оны хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан зам, тээврийн салбарын төсөл, арга хэмжээг Зам, тээврийн хөгжлийн яамны 2024 оны төлөвлөгөөнд бүрэн тусгасан. Мөн уг төлөвлөгөөг хэрэгжүүлэх эзэнжүүлсэн /нарийвчилсан/ төлөвлөгөөг боловсруулан батлуулсан.
9.5	Салбарт хэрэгжих логикийн төслүүдийн төлөвлөлтийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх	Жилийн эцсийн байдлаар: Тээвэр логикийн чиглэлээр хэрэгжих төсөл арга хэмжээг хөгжлийн бодлого, төлөвлөлтөд тусгуулна.	БТГ	Засгийн газрын 2024-2028 оны мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд тусгагдсан тээвэр логикийн чиглэлээр хэрэгжүүлэх арга хэмжээг Нийслэлийн Засаг даргатай байгуулах 2024 оны төлөвлөгөөнд тусган 2024 оны 02 дугаар сард Аймаг, нийслэлийн Засаг дарга нартай гэрээ байгуулах үеэр ЗТХ-ийн сайд, Нийслэлийн Засаг дарга нараар батлуулсан. Хөшигийн хөндийн тээвэр логикийн төв, Алтанбулгийн тээвэр логикийн төвийн санхүүжилтийг шийдвэрлэх зорилгоор Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр 2024-2028 онд хэрэгжүүлэх төслийн жагсаалтад тусгуулахаар 2024-04-24-ны өдрийн 02/1791

**ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ**

				дугаар тоот албан бичгээр ЭЗХЯ-д хүргүүлсэн.
--	--	--	--	--

Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд хариуцсан нэгж, хэрэгжүүлэх үндсэн чиг үүргээр /давхардсан тоогоор/ хэрэгжилтийг авч үзвэл:

/Хүснэгт 3/

№	Нэгж	Нийт	100	90	70	50	30	0	Хугацаа болоогүй	Үнэлгээ
1	БТГ	15	6	2	2	2	3	-	-	74.0
2	АЗБЗГ	33	12	9	3	5	4	-	-	78.5
3	ИНБЗГ	18	10	3	1	3	1	-	-	84.4
4	АТБЗГ	25	12	1	5	5	2	-	-	78.0
5	ТЗДТБЗГ	40	16	4	6	9	5	-	-	74.5
6	ТЗУГ	22	8	11	3	-	-	-	-	90.9
7	ХШУДАГ	6	2	3	1	-	-	-	-	90.0
8	СХГ	9	7	2	-	-	-	-	-	97.8
Нийт		168	73	35	21	24	15	-	-	80.7

3. Төлөвлөлт, үнэлэлтийн байдал:

3.1. Албан хаагчид өөрийн хариуцсан ажил, арга хэмжээг тайлагнахдаа хайхрамжгүй хандах, утга найрууллгын алдаатай болон биелэлтийг шинэчлэн тайлагнахгүй байгаа нь төлөвлөгөөний хэрэгжилтийг үнэлэхэд хүндрэлтэй байна. Мөн төлөвлөгөөний хэрэгжилтийг үнэлсэн дундаж үнэлгээ өсөхгүй байна.

3.2. Зам, тээврийн яамны 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд туссан 145 арга хэмжээний хэрэгжилт бүрэн хэрэгжсэн 60 арга хэмжээ, 90 хувийн 33, 70 хувийн 15, 50 хувийн 24, 30 хувийн 13 арга хэмжээний хэрэгжилт **80.1** хувь байна. Харин яамны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд хариуцсан нэгжүүдийн давхардсан тоогоор 168 арга хэмжээний үнэлгээний дундаж 80.7 хувьтай байна.

3.3. 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний III улирлын хэрэгжилтийг шинэчлэн батлагдсан төлөвлөгөөний хэрэгжилттэй харьцуулахад 6.9 функтээр буурсан байна. Энэ нь өмнөх төлөвлөгөөнөөс 12 арга хэмжээ хасагдсан ба 7 арга хэмжээ нь 100 хувийн биелэлттэй байсан нь төлөвлөгөөний дундаж үнэлгээ буурахад нөлөөлсөн байна.

3.4. Зам, тээврийн яамны 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд өмнөх улиралд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлангаар өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн төлөвлөгөөг шинэчлэн баталсан байна.

4. Санал, зөвлөмж:

4.1. Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд эрчимжүүлэх шаардлагатай 30-50 хэрэгжилттэй 37 арга хэмжээ нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрээгүй байгаа тул төсөв хөрөнгө шаардлагагүй нэг удаагийн ажлын хэсгийг хуралдуулах, тайлан тооцоог дуусгах, үнэлгээний хорооны ажлыг эрчимжүүлэхэд үнэлгээ дахих боломжтой байна.



ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ

4.2. Яамны 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулахдаа бодлогын баримт бичигт шинээр туссан арга хэмжээг бүрэн тусгах, төлөвлөгөөний зорилтод түвшин, хэрэгжүүлэх хугацаа зэргийг нэгжийн төлөвлөгөөтэй уялдуулах болон Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газраас ирүүлсэн зөвлөмжийн дагуу төлөвлөгөөг боловсруулж ажиллахыг БТГ-т;

4.3. Яамны 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний төслийг хянах, нэгжүүдийн гүйцэтгэлийн төлөвлөгөөтэй уялдуулан боловсруулахад холбогдох санал, зөвлөмжийг өгч ажиллахыг ХШҮДАГ-т;

4.4. Албан хаагч бүр өөрийн хариуцсан арга хэмжээг заасан хугацаанд бүрэн гүйцэтгэт тайлагнах, нэгжийн дарга нар тэдгээр арга хэмжээг хянаж ажиллахыг тус тус зөвлөж байна.



Хавсралт 2

**ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМНЫ
“ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН СУРГАЛТ, АЖИЛЛАХ НӨХЦӨЛ, НИЙГМИЙН
БАТАЛГААГ ХАНГАХ ХӨТӨЛБӨР”-ИЙН ХЭРЭГЖИЛТЭД
2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН БАЙДЛААР ХИЙСЭН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ
АЖЛЫН ТАЙЛАН**

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын зорилго:

“Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-ийн хэрэгжилтэд 2024 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ хийж, үнэлэлт, дүгнэлт өгөх, цаашид анхаарч ажиллах асуудлын талаар санал, зөвлөмж боловсруулах замаар яамны удирдлага, албан тушаалтныг холбогдох мэдээллээр хангах зорилгоор энэхүү хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг хийлээ.

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ үнэлгээ хийх нийтлэг журам”-д Засгийн газрын 2021 оны 374 дүгээр тогтоолоор нэмэлт өөрчлөлт орсон. Тус тогтоолоор баталсан хавсралтад заасан хүснэгтийн дагуу “Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-ийн биелэлтийг Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний программд тайлагнаж ажиллалаа.

Хоёр. Танилцуулга:

Зам, тээврийн яамны “Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-ийн биелэлтийг 2024 оны жилийн эцсийн байдлаар үнэлэхэд **97.1** хувьтай байна. Хөтөлбөрт туссан 7 зорилтын хэрэгжилтийн үнэлгээг хүснэгтээр үзүүлбэл:

		/Хүснэгт 1/
№	Үйл ажиллагаа	Хэрэгжилт /хувиар/
1. Хүний нөөцийг хөгжүүлэх, идэвхжүүлэх		
1	Засгийн газар, төрийн байгууллага, бусад байгууллагаас албан хаагчдын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулсан дотоод сургалт	100
2	Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр байгууллагын болон зохион байгуулагч талын зардлаар хамруулсан гадаад сургалт	100
3	Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр зарцуулсан зардал, албан хаагчдын шилжилт хөдөлгөөн	100
2. Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах		
4	Цалин хөлс, шагнал, урамшууллын тогтолцоог хэрэгжүүлэх	100
5	Албан хаагчдын ажлын байрны хэвийн нөхцөлийг бүрдүүлэх	90
6	Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх	100
7	Албан хаагчдыг нийгмийн баталгааг хангах чиглэлээр зарцуулсан зардал	90



ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ

Хөтөлбөрийн зорилтыг хэрэгжүүлэх 26 арга хэмжээний үнэлгээг хүснэгтээр үзүүлбэл:

/Хүснэгт 2/

№	Дэс дугаар	Шалгуур үзүүлэлт	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин	Үнэлгээ
1. ХҮНИЙ НӨӨЦИЙГ ХӨГЖҮҮЛЭХ, ИДЭВХЖҮҮЛЭХ					
1. Засгийн газар, төрийн байгууллага, бусад байгууллагаас албан хаагчдын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулсан дотоод сургалт					
1	1.1	Нийт сургалт, семинар, зөвлөгөөний тоо:	13	23	100
2		Ажлын байран дахь сургалт	4	4	100
3		Мэргэшүүлэх сургалт	30	20	70
4		Туршлага солилцох арга хэмжээ	-	-	100
5		Бусад	2	3	100
6	1.2.	Хамрагдсан нийт албан хаагчдын тоо:	87	303	100
7		Эмэгтэй албан хаагч	-	190	100
8		Эрэгтэй албан хаагч	-	113	100
9		Удирдах албан тушаалтан	10	10	100
10		Гүйцэтгэх, туслах албан тушаалтан	77	293	100
11	1.3.	Албан хаагчдыг сургалтад хамруулсан байдал: Нийт албан хаагчдад эзлэх хувь	70-ээс дээш	100%	100
2. Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр байгууллагын болон зохион байгуулагч талын зардлаар хамруулсан гадаад сургалт					
12	2.1.	Нийт гадаад сургалт, семинар, зөвлөгөөний тоо	-	19	100
13	2.2.	Хамрагдсан нийт албан хаагчдын тоо:	-	39	100
14		Эмэгтэй албан хаагч	-	21	100
15		Эрэгтэй албан хаагч	-	18	100
16		Удирдах албан тушаалтан	-	2	100
17		Гүйцэтгэх, туслах албан тушаалтан	-	37	100
18	2.3.	Гадаад сургалтад хамруулсан байдал: Нийт албан хаагчдад эзлэх хувь	20-оос дээш	25.8%	100
3. Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр зарцуулсан зардал, албан хаагчдын шилжилт хөдөлгөөн					
19	3.1.	Албан хаагчдын сургалт, хөгжлийн үйл ажиллагаанд зарцуулсан зардлын хэмжээ (сая.төг)	-	5,195,000	100
20	3.2.	Албан хаагчдын шилжилт хөдөлгөөний хувь	15-аас доош	4.6%	100
2. АЛБАН ХААГЧДЫН НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ					
4. Цалин хөлс, шагнал, урамшууллын тогтолцоог хэрэгжүүлэх					
21	4.1.	Цалин, шагнал, урамшуулалд зарцуулсан зардлын		49%	100



ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ

		байгууллагын нийт төсөвт эзлэх хувь			
22	4.2.	Нэгж албан хаагчид олгох хоол, унааны нэмэгдэл (мян.төг)		37000	100
5. Албан хаагчдын ажлын байрны хэвийн нөхцөлийг бүрдүүлэх					
23	5.1.	Ажлын байрны таатай орчны сэтгэл ханамжийн санал асуулгын дүн (Албан хаагчдын сэтгэл ханамж)	80-аас дээш	86.3%	100
6. Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх					
24	6.1.	Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг (Жилд)	1-ээс дээш	1	100
25	6.2.	Албан хаагчдын хамрагдалт	90-ээс дээш	72.8%	70
7. Албан хаагчдыг нийгмийн баталгааг хангах чиглэлээр зарцуулсан зардал					
26	7.1.	Албан хаагчдын нийгмийн асуудалд зарцуулсан зардлын хэмжээ (сая.төг)	-	170.7 (сая.төг)	70

3. Үнэлэлт, дүгнэлт:

3.1. . Засгийн газрын 2020 оны 206 дүгээр тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д заасны дагуу “Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр”-ийн хэрэгжилт 2024 оны жилийн эцсийн байдлаар **97.1** хувьтай байна.

3.2. “Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх 26 арга хэмжээнээс зорилтод түвшинд хүрсэн бүрэн хэрэгжсэн 23, 70 хувийн хэрэгжилттэй 3 арга хэмжээний дундаж үнэлгээ 96.5 хувьтай байна.

3.3. Хөтөлбөрийн зорилтыг хэрэгжүүлэх 26 арга хэмжээнд 70 хувийн хэрэгжилттэй 3 арга хэмжээ нь төлөвлөсөн зорилтод түвшинд хүрээгүй байна. Үүнд:

1.1.3. Мэргэшүүлэх сургалтад хамрагдах албан хаагчдын тоо;

6.2. Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан албан хаагчдын тоо;

7.2. Албан хаагчдын нийгмийн асуудалд зарцуулсан зардлын хэмжээ.

3.4. Төрийн нарийн бичгийн даргын 2023 оны Б/88 дугаар тушаалаар “Зам, тээврийн хөгжлийн яамны албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”, Төрийн нарийн бичгийн даргын 2023 оны А/74 дугаар тушаалаар “Сургалтын хөтөлбөр”-ийг тус тус баталсан байна. Гэвч эдгээрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөгүй мөн хөтөлбөрийн зарим арга хэмжээг хэрэгжүүлэхэд санхүүжилтгүй тусгагдаагүй байна. Тухайлбал: Албан хаагчдын нийгмийн асуудалд зарцуулсан зардал нь албан хаагчдад нөхөх төлбөр, тэтгэвэр тэтгэмж, буцалтгүй тусламж олгосон тухай тайлагнасан ба албан хаагчдын нийгмийн баталгааг хангахад чиглэсэн төсөвгүй байна.

4. Санал, зөвлөмж:



ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ

4.1. Төрийн нарийн бичгийн даргын 2023 оны Б/88 дугаар тушаалаар баталсан "Зам, тээврийн хөгжлийн яамны албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх 2025 оны нарийвчилсан төлөвлөгөө, мөн төлөвлөгөөг хэрэгжүүлэх зардлыг тооцон, төсөвт тусган батлуулж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газарт;

4.2. Мэргэшүүлэх сургалтад хамрагдах албан хаагчдын тоо нь зорилтод түвшинд хүрээгүй тул мэргэшүүлэх сургалтад хамрагдах албан хаагчдын судалгааг гаргаж, он тус бүрээр хүрэх боломжит зорилтыг төлөвлөх, албан хаагчдын эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт албан хаагчдын 72.8 хувьтай хамрагдсан ба эрүүл мэндийн үзлэгийг хамрагдалтыг нэмэгдүүлэх, үзлэгийн ач холбогдлыг сурталчлан таниулах, албан хаагчдын нийгмийн асуудалд зарцуулсан зардлын хэмжээг төсөвт суулгах, нэмэгдүүлэх чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газарт;

4.3. Төрийн захиргааны удирдлагын газраас "Зам, тээврийн хөгжлийн яамны албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр", "Сургалтын хөтөлбөр"-ийн биелэлтийг хагас бүтэн жилээр гаргуулж хэвших, хэрэгжилтэд тухай бүр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үр дүнг албан хаагчдад мэдээлж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт;газарт

4.4. Төрийн нарийн бичгийн даргын 2023 оны Б/88 дугаар тушаалаар баталсан "Зам, тээврийн хөгжлийн яамны албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр"-ийн 2.1-т "Төрийн албан хаагчийн ажиллах урам зориг, хүсэл эрмэлзэлийг бий болгох, сэтгэл ханамжийн баталгаатай байх нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэгдсэн хөдөлмөрийн харилцаан дахь урамшуулал, идэвхжүүлэлтийн аргад тулгуурласан олон талт үйл ажиллагааг тодорхойлох, хэрэгжүүлэх замаар төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл нийгмийн баталгааг хангахад энэхүү хөтөлбөрийн зорилго оршино" гэж заасан бөгөөд хөтөлбөрийн зорилгыг бүрэн хэрэгжүүлэн ажиллахад хяналт тавьж ажиллахыг нийт албан хаагчдад тус тус зөвлөж байна.



Хавсралт 3

ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТИЙН МЭДЭЭЛЛИЙГ ИЛ ТОД БАЙДЛЫН ХЭРЭГЖИЛТЭД 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН БАЙДЛААР ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ АЖЛЫН ТАЙЛАН

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго:

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулиар заасан үндэслэл, журмын дагуу иргэний мэдээлэл хайх, хүлээн авах эрхийг хангах, нийтийн мэдээллийн дэд бүтцийн эрх зүйн үндсийг тогтоох, төрийн үйл ажиллагааг цахим хэлбэрээр явуулах, нээлттэй, ил тод, шуурхай байлгах, төрийн үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгоход оршино.

Хоёр. Танилцуулга:

Төрийн үйл ажиллагааг нээлттэй, ил тод, хүнд сурталгүй, авилгаас ангид байлгах, иргэдэд үйлчлэх үйлчилгээг ил тод хөнгөн шуурхай болгох, хангах талаар Зам, тээврийн яамнаас хийж буй ажлын явцыг Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ, хийх нийтлэг журам”-ын 9 дүгээр хавсралтад заасны дагуу Мэдээллийн ил тод байдлын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ.

Зам, тээврийн яамны Нийтийн мэдээллийн ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн 5 хэсгийн 46 арга хэмжээний хэрэгжилт 2024 оны жилийн эцсийн байдлаар 92.8 хувь байна. Шалгуур үзүүлэлт тус бүрийн үнэлгээг хүснэгтээр харуулбал:

/Хүснэгт 1/

Хэсэг	Нийт арга хэмжээ	Үнэлгээ /хувиар/					Хамаарахгүй	ХШҮ
		100	70	30	0	Хугацаа болоогүй		
1	10	9	-	1	-	-	-	93.0
2	6	5	-	-	1	-	-	83.3
3	15	13	1	1	-	-	-	93.3
4	2	2	-	-	-	-	-	100.0
5	13	8	1	-	-	-	4	96.2
Нийт	46	37	2	2	1	-	4	92.8

2024 оны жилийн эцсийн байдлаар Зам, тээврийн яамны мэдээллийн ил тод, нээлттэй байдлын шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтэд 0-70 хувийн хэрэгжилттэй үнэлэгдсэн 5 арга хэмжээг дурдвал:

/Хүснэгт 2/

№	Арга хэмжээ	Хэрэгжилт	Үнэлгээ
	Нэг. Чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал		



ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ

1	Хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлан	Хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний одоогоор хийгдсэн хууль байхгүй байна. Харин яамны сайтад хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хийсэн ХШҮ-ний тайланг тухай бүр нээлттэй байршуулан ажиллаж байна.	30
Хоёр. Хүний нөөцийн мэдээллийн ил тод, нээлттэй байдал			
2	Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж үнэлэх журам	Зам, тээврийн салбарын хүний нөөцийн стратеги, бодлогын боловсруулж байгаа бөгөөд салбарын байгууллагууд болон зам, тээврийн чиглэлээр суралцаж буй оюутан залуусын санал, зөвлөмжийг тусгасан урт хугацаандаа хэрэгжүүлэх бодлого, мөн харьяа байгууллага бүрийг өөрийн салбар үйл ажиллагаатай уялдуулан Хүний нөөцийн стратеги төлөвлөгөө боловсруулан батлуулахыг үүрэг болгосон.	0
Гурав. Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал			
3	Мэдээлэл хариуцагч болон захиалагч байгууллагын хүсэлтээр холбогдох этгээдийг худалдан авах ажиллагааны мэргэжил, арга зүйн зөвлөгөө, зааварчилгаагаар хангасан тухай мэдээлэл	Худалдан авах ажиллагаатай холбоотой мэдээллийг байршуулав.	30
4	Төсвийн хөрөнгөөр болон гадаад зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн санхүүжилт, хэрэгжилт, явц, үр дүн	Төсвийн хөрөнгөөр болон гадаад зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн санхүүжилт, хэрэгжилт, явц, үр дүнгийн талаар нээлттэй тухай бүр мэдээлсэн байна	70
Тав. Бусад мэдээллийн ил тод, нээлттэй байдал			
5	Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хувийн эрх зүйн хуулийн этгээдийн нэр, хаяг, дүрэм, үйл ажиллагааны чиглэл, эрх бүхий этгээдийн оруулсан хөрөнгийн хувь хэмжээ, ашиг, алдагдлын тайлан, нэгдсэн төсөвт төлсөн татварын хэмжээ, ногдол ашиг	Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хувийн эрх зүйн хуулийн этгээдийн нэр, хаяг, дүрэм, үйл ажиллагааны чиглэл зэргийг мэдээлсэн. Байгууллагын хөрөнгийн хувь хэмжээ, ашиг, алдагдлын тайлан, нэгдсэн төсөвт төлсөн татварын хэмжээ, ногдол ашиг зэрэг мэдээлэл шилэн дансын мэдээлэлд багтсан болно.	70

Засгийн газрын 49 дүгээр тогтоолын хавсралтад заасан цахимжилтыг эрчимжүүлж, төрийн байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг хангаж, хүнд суртлыг арилгахаар “Шил ажиллагаа”-ны хүрээнд “shilen.gov.mn” системээр Нийтийн мэдээллийг ил тод байдлын тухай хуульд заасан 98 мэдээ, мэдээллийн хэрэгжилтийг бүх шатны төрийн байгууллага хангуулахаар www.shilen.gov.mn дээр тайлагнаж, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам хяналт тавьж ажиллаж байна. Яамны нээлттэй мэдээллийн ил тод байдлын 5 хэсгийн 98 шалгуур үзүүлэлтийн хэрэгжилт 2024 оны жилийн эцсийн байдлаар 92.4 хувь байна. Шалгуур үзүүлэлт тус бүрийн үнэлгээг хүснэгтээр харуулбал:

/Хүснэгт 3/

№		Авбал зохих оноо	Авсан оноо	
---	--	------------------	------------	--



ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ

	Хэсгийн дугаар	Арга хэмжээний тоо			Шилэн индексийн үнэлгээ
1	1	18	2160	1900	86.96
2	2	7	840	750	89.29
3	3	29	2040	1980	97.06
4	4	6	720	660	91.67
5	5	27	1320	1255	95.08
Нийт		98	7080	6545	92.44

Гурав. Үнэлэлт, дүгнэлт:

3.1. Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ, хийх нийтлэг журам”-ын 9 дүгээр хавсралтад заасан Нийтийн мэдээллийн ил тод байдлын шалгуур үзүүлэлтэд заасан 46 арга хэмжээний хэрэгжилт 2024 оны жилийн эцсийн байдлаар 92.8 хувь байна.

3.2. Засгийн газрын 49 дүгээр тогтоолын хавсралтад заасан цахимжилтыг эрчимжүүлж, төрийн байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг хангаж, хүнд сурталыг арилгахаар “Шил ажиллагаа”-ны хүрээнд “shilen.gov.mn” системээр Нийтийн мэдээллийг ил тод байдлын тухай хуульд заасан 98 мэдээ, мэдээллийн хэрэгжилтийг бүх шатны төрийн байгууллага хангуулах үүрэг өгөгдсөн. Зам, тээврийн яамны “shilen.gov.mn” системээр ил тод байдлын хэрэгжилтийг тайлагнасан ба Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам 92.4 хувиар үнэлсэн байна.

3.3. Зам, тээврийн яамны Нийтийн мэдээллийн ил тод байдлын хэрэгжилтэд онцлон анхаарч яамны үүдний хэсэгт дижитал самбарыг ажиллуулж, мэдээллийн самбарын мэдээ, мэдээллийг тухай бүр шинэчлэн байршуулан ажилласан байна.

3.4. “Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль”-д нууцын тухай хуульд хамаарах нууц баримт бичиг, мэдээ, мэдээллээс бусад арга хэмжээг тайлагнах ба төрийн үйл ажиллагааг цахимаар нээлттэй, ил тод, хүнд сурталгүй иргэдэд үйлчлэх, үйлчилгээг ил тод, хөнгөн шуурхай болгоход чиглэсэн байгааг анхаарч, мэдээ мэдээллийг тайлагнан ажилласан нь сайшаалтай байна.

Дөрөв. Санал, зөвлөмж:

4.1. Мэдээлэл хариуцагч нээлттэй мэдээллийн ил тод байдлыг хангахад Засгийн газрын 2022 оны 201 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Нээлттэй мэдээллийг цахим хэлбэрээр байршуулж нийтлэх, шинэчлэх, хяналт тавих нийтлэг журам”-ыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллахыг БТГ-т;

4.2. Мэдээ, мэдээллийг цахим хуудсанд мэдээлэх ажлыг хариуцсан мэргэжилтэн нар хариуцлагатай байлгах, тухай бүр мэдээллийг шинэчлэх, тайлан мэдээг бүрэн байршуулах, цахим хуудсанд байршсан хуучирч цаг хугацааны хувьд үнэ цэнэ алдсан мэдээллүүдийг устгах, цахим мэдээллийн самбарт мэдээллийг шинэчлэх зэрэгт анхаарч, байнгын хяналт тавьж ажиллахыг ХШҮДАГ-т;



ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ

4.3. Нээлттэй мэдээллийн ил тод байдлыг яамны цахим самбар болон бусад аргаар олон нийтэд түгээх, төрийн үйлчилгээг ил тод, хүнд сургалтгүй байлгахад анхаарч, мэдээллийн баяжуулалтыг тухай бүр хийх зэрэг зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг нийт албан хаагчид анхаарах;

4.4. Нээлттэй мэдээллийн ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн биелэлтийг цаг хугацаа, тоо баримттай, холбогдох цахим холбоосны хамт тайлагнаж байхыг яам болон харьяа байгууллагын албан хаагчдад тус тус зөвлөж байна.

ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ.